



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ЗӨРЧИЖ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛИЙГ БАТАЛСААР БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/02-НА-СТА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор Д.Энхболд

Утас: 263755, Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn

Аудитын менежер Х.Баярмаа

Утас: 261639, Цахим хаяг: bayarmaakh@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Сандуйжав, Б.Багчимэг, Ю.Энхтуяа

Аудитор: Ц.Цолмон, Ж.Оюунтуяа, Л.Энх-Амгалан,

М.Сангижанцан, Ч.Бумдарь, И.Дэлгэнтүүл, Б.Ууганбилэг

Монгол улс, Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: +976 51-261585, Факс: +976 11-323266, 11-324853
И-мэйл: info@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн жагсаалт	4
Дүрслэлийн жагсаалт	4
БҮЛЭГ 1: ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГААГААС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ӨГӨӨЖ БУУРЧ, ТӨСӨВТ АЧААЛАЛ ҮҮСЭЖ БАЙНА	7
Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь хэрэгцээ шаардлага, эдийн засгийн үр ашиг багатай олон жижиг арга хэмжээнд чиглэгдсэн байна	9
Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийн ихэнх нь төсөвлөлтийн шаардлага хангахгүй байна	11
БҮЛЭГ 2: ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ОНОВЧТОЙ ХУВААРИЛААГҮЙ БАЙНА	18
Магадлалаар баталгаажсан зураг, төсөвгүй худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа нь шалгарсан компанид давуу байдал олгож, худалдан авах ажиллагааны зарчмыг алдагдуулж байна	18
Ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээнүүдийн санхүүжилтийн шийдвэрлэлт хангалтгүйгээс цаашид ТАХ зогсох, үр ашиггүй болох, өртөг нэмэгдэх эрсдэл үүсгэж байна.	21
Зарим төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна. ...	33
Зарим төсөл, арга хэмжээний ашиглалт хангалтгүй байна.....	36
БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ, САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЯНАХ, ТАЙЛАГНАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА	38
2022 онд улсын хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3312 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн байна.....	38
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт улсын болон орон нутгийн хөгжлийн бодлогыг дэмжиж байгаа гэх үндэслэл хангалтгүй байна	42
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 60 хувь нь бүрэн хэрэгжиж дууссан байна.....	43
ДҮГНЭЛТ.....	46
ЗӨВЛӨМЖ.....	47
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	49
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР	53

Товчилсон үгийн тайлбар

ТБОНӨХБАҮХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ
АТХ	худалдан авах тухай хууль
БТХ	Барилгын тухай хууль
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ЗГ	Засгийн газар
МУЕС	Монгол улсын Ерөнхий сайд
ЗГХЭГД	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
СаС	Сангийн сайд
ЗТХС	Зам тээврийн хөгжлийн сайд
СоС	Соёлын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ЭХС	Эрчим хүчний сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЗТХЯ	Зам тээврийн хөгжлийн яам
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
НХГХ	Нэмэгдүүлсэн хөрөнгө гарцын харьцаа
ХАА	Худалдан авах ажиллагаа
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДЦС	Дулаан цахилгаан станц
ГЛ	Гаалийн төв лаборатори
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар

ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ААН	Аж ахуйн нэгж
ХХК	Хязгаарлагдмал, хариуцлагатай компани
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ТАХ-ний ерөнхий мэдээлэл	7
Хүснэгт 2	ТАХ-ний ерөнхий мэдээлэл	7
Хүснэгт 3	Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний төсөвт өртөг, санхүүжих дүнгийн харьцаа	8
Хүснэгт 4	Нэг хүд ногдох улсын төсвийн хөрөнгө оруулалтын дүн	8
Хүснэгт 5	ТАХ бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал	9
Хүснэгт 6	Магадлалгүй батлагдсан ТАХ-ний тоо	11
Хүснэгт 7	Шилжин хэрэгжиж байгаа ТАХ-нд шинэ ТАХ-тай адил иж бүрэн магадлал хийсэн байдал	13
Хүснэгт 8	15.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ТАХ	14
Хүснэгт 9	УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд нэмэгдсэн ТАХ-ний мэдээлэл	15
Хүснэгт 10	Задарсан ТАХ-ний ажлын гүйцэтгэл	16
Хүснэгт 11	6-11 жил үргэлжилж байгаа ТАХ	17
Хүснэгт 12	Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний ХАА-ны мэдээлэл	18
Хүснэгт 13	ТАХ-ний ажлын гүйцэтгэл	21
Хүснэгт 14	Салбаруудад зарцуулсан санхүүжилтийн мэдээлэл	21
Хүснэгт 15	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг	22
Хүснэгт 16	Хэрэгжилт дутуу ТАХ-ний мэдээлэл	23
Хүснэгт 17	Хэрэгжээгүй ТАХ-ний мэдээлэл	23
Хүснэгт 18	ТАХ-г багцад хуваасан мэдээлэл	31
Хүснэгт 19	Дараа онуудад хэрэгжүүлэх ТАХ-ний зураг, төсвийн гүйцэтгэл ашиглалт	36
Хүснэгт 20	Төсвийн хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй ТАХ	37
Хүснэгт 21	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд батлагдсан төсөв	39
Хүснэгт 22	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ангилал	42
Хүснэгт 23	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөв, гүйцэтгэлийн харьцуулалт	43
Хүснэгт 24	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болон хэрэгжсэн төсөл арга хэмжээний дүн	44

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ТАХ-ний задарсан тоо	15
Дүрслэл 2	УТХО-н Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын дүн болон ДНБ-нд эзлэх хувь	22
Дүрслэл 3	ГЛ-ийн 2022 он болон 2021 онтой харьцуулсан байдал	27

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/04 дүгээр тушаалыг үндэслэн "Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд"-д гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилго

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн. Үг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх;
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлсэн эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг 2022 онд хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч болон тэдгээрийн харьяа байгууллагууд, Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Зам, тээврийн хөгжлийн төв, холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах зэрэг аудитын арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд:

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль,

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,

Барилгын тухай хууль,

Эрчим хүчний тухай хууль,

Авто замын тухай хууль,

"Алсын хараа" 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого,

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл",

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,

Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам",

Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам",

Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан "Харьцуулалтын аргаар бараа худалдан авах төндөрийн жишиг баримт бичиг",

Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд",

Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт,

Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд,

Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд удирдаж, аудитын менежер Х.Баярмаа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Сандуйжав, Б.Батчимэг, Ю.Энхтуяа, аудитор Ц.Цолмон, Ж.Оюунтуяа, Л.Энх-Амгалан, М.Сангисүрэн, Ч.Бумдарь, И.Дөлгөөнтуул, Б.Ууганбилэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Аудитын хамрах хүрээнд зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хөндлөнгийн мэргэжлийн шинжээчээр дүгнэлт гаргуулан, үр дүнг аудитын дүгнэлтэд ашиглалаа

БҮЛЭГ 1: ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГААГААС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ӨГӨӨЖ БУУРЧ, ТӨСӨВТ АЧААЛАЛ ҮҮСЭЖ БАЙНА.

1.1. Монгол Улсын 2022 оны төсвийн хууль, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулиар нийт 6,152.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1369 ТАХ-г 1,393.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. ТАХ-ний ерөнхий мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1: ТАХ-ний ерөнхий мэдээлэл /тэрбум төгрөг/

Ангилал	Шилжих ТАХ			Шинэ ТАХ			Нийт ТАХ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга, байгууламж	615	2,822.5	769.1	447	2,626.8	422.5	1062	5,449.4	1,191.6
Их засвар	53	45.4	13.8	55	110.0	36.3	108	155.4	50.2
Тоног төхөөрөмж	30	255.2	30.3	140	204.8	96.2	170	459.9	126.5
ТЭЗҮ	7	71.6	21.5	22	16.0	4.0	29	87.6	25.4
Нийт	705	3,194.7	834.7	664	2,957.6	559.0	1369	6,152.3	1,393.7

Эх сурвалж: Монгол улсын 2022 оны төсвийн тухай хууль

Нийт ТАХ-ний 51.5 хувь буюу 705 нь өмнөх оноос шилжсэн, 48.5 хувь буюу 664 нь шинээр батлагдан хэрэгжсэн байна. Өмнөх оноос шилжин хэрэгжсэн ТАХ-ний 87.2 хувь буюу 615 нь барилга, байгууламж байна.

Тоног төхөөрөмж, ТЭЗҮ нь тухайн онд бүрэн хэрэгжих боломжтой ч нийт 37 ТАХ өмнөх оноос шилжин хэрэгжсэн байна. Энэ нь тоног төхөөрөмж, ТЭЗҮ-ийн хувьд төлөвлөлт, төсөвлөлт алдаатай байгааг харуулж байна.

Хүснэгт 2: ТАХ-ний ерөнхий мэдээлэл /тэрбум төгрөг/

Ангилал	Эрх шилжсэн ТАХ			Эрх шилжээгүй ТАХ			Нийт ТАХ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга, байгууламж	575	2,010.9	526.9	487	3,438.5	664.6	1062	5,449.4	1,191.5
Их засвар	79	95.9	29.6	29	59.5	20.5	108	155.4	50.2
Тоног төхөөрөмж	100	138.8	72.9	70	321.0	53.7	170	459.9	126.5
ТЭЗҮ	7	6.7	1.5	22	80.9	24.0	29	87.6	25.5
Нийт	761	2,252.3	630.9	608	3,899.9	762.8	1369	6,152.3	1,393.7

Эх сурвалж: ТЕЗ-дын эрх шилжүүлсэн тушаал

Нийт ТАХ-ний 55.5 хувь буюу 761-г орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн байна. Эрх шилжин хэрэгжиж байгаа ТАХ-ний тухайд холбогдох мэдээлэл нь ТЕЗ-д хангалттай байдаггүй буюу эрх шилжсэн гэх байдлаар хандах нь түгээмэл байна. Энэ нь ТАХ-ний нэгдсэн хяналтын тогтолцоо алдагдах нөхцөлийг бий болгож байна.

1.2. Дээрх мэдээллүүдээс харахад ТАХ-ний тухайн жилд санхүүжүүлэх дүн нь төсөвт өртөгтэй харьцуулахад харьцангуй бага буюу ЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан

"Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.3.4.2¹-г хангахгүй байна.

1.3. ТАХ-ний тухайн жилийн санхүүжих дүнг авч үзэхэд 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан нийт 664 ТАХ-ээс 66.5 хувь буюу 442 нь дээрх журмын заалттай нийцээгүй байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3: Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний төсөвт өртөг, санхүүжих дүнгийн харьцаа /тэрбум төгрөг/

№	ТАХ-ний тоо	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2022 оны санхүүжилтийн	
				дүн	Хувь
1	368	2022 – 2023	1,467.0	212.4	14.5
2	70	2022 – 2024	826.2	67.7	8.2
3	4	2022 – 2025	390.6	32.8	8.4
Нийт	442				

Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль

Энэ нь ТАХ төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй удааширч төсөвт өртөг нэмэгдэн үргүй зардал гарах нөхцөлийг бий болгоход нөлөөлж байна.

1.4. Нийт ТАХ-ний төсөвт өртөг, тухайн жилийн санхүүжих дүн болон гүйцэтгэлийн нэг хүнд ногдох үзүүлэлтийг аймаг, нийслэлээр харуулбал:

Хүснэгт 4: Нэг хүнд ногдох улсын төсвийн хөрөнгө оруулалтын дүн. Аймаг, нийслэлээр /сая төгрөг/

Аймаг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжи х дүн	Гүйцэтгэл	Хүн амын тоо	Нэг хүнд ногдох хөрөнгө оруулалт		
						Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гүйцэтгэл
Хэнтий	86	613,720.6	162,590.6	171,353.75	78959	7.77	2.06	2.17
Дорнод	36	329,503.2	48,000.7	39,791.29	83704	3.94	0.57	0.48
Төв	35	342,905.7	52,094.7	50,879.53	92038	3.73	0.57	0.55
Архангай	55	282,047.2	51,527.7	46,772.86	93149	3.03	0.55	0.50
Ховд	53	221,813.0	53,228.7	52,148.32	91071	2.44	0.58	0.57
Говь-Алтай	65	128,620.4	34,714.1	29,271.80	57098	2.25	0.61	0.51
Дархан-Уул	49	241,889.6	69,073.4	58,891.72	107932	2.24	0.64	0.55
Говьсүмбэр	9	39,517.2	8,310.9	6,926.41	18007	2.19	0.46	0.38
Хөвсгөл	89	258,949.6	60,451.9	48,401.31	136633	1.90	0.44	0.35
Баян-Өлгий	64	204,977.4	43,526.3	40,798.09	114776	1.79	0.38	0.36
Увс	74	143,446.0	27,964.1	20,609.65	83964	1.71	0.33	0.25
Дундговь	27	77,549.3	17,382.4	14,883.43	46387	1.67	0.37	0.32
Баянхонгор	32	136,466.4	30,357.8	28,064.90	88397	1.54	0.34	0.32
Булган	30	86,887.1	13,712.6	10,868.21	61161	1.42	0.22	0.18
Завхан	44	100,771.6	21,800.4	19,085.07	71798	1.40	0.30	0.27
Сүхбаатар	31	75,137.0	29,804.9	25,934.49	65214	1.15	0.46	0.40
Улаанбаатар	374	1,778,601.3	357,155.6	290,087.41	1691766	1.05	0.21	0.17
Дорноговь	14	73,898.0	16,570.1	16,292.67	71129	1.04	0.23	0.23

¹ шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төслийн нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төслийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах

Сэлэнгэ	51	106,406.2	30,239.8	25,377.35	107341	0.99	0.28	0.24
Өвөрхангай	53	89,782.5	37,054.2	40,703.95	114962	0.78	0.32	0.35
Орхон	28	83,188.7	21,353.6	16,211.90	109125	0.76	0.20	0.15
Өмнөговь	21	41,399.2	6,181.5	4,866.02	72937	0.57	0.08	0.07
Улсын хэмжээнд баталсан ТАХ	46	686,447.2	192,259.8	172,030.47	3457548	0.20	0.06	0.05
Элчин сайдын яам	3	8,400.0	8,400.0	7,914.04			Улсын дундаж	
Нийт	1369	6,152,324.4	1,393,755.8	1,238,164.64	3457548	1.78	0.40	0.36

Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, 1212.мп

1.5. Дээрх үзүүлэлтээс харахад улсын төсвийн хөрөнгө оруулалтын хуваарилалт харилцан адилгүй байна. Нийт 11 аймаг болон нийслэл улсын дундаж үзүүлэлтээс доогуур байна. Харин Хэнтий аймаг бусад аймаг, нийслэл, улсын дундажтай харьцуулахад хэт өндөр үзүүлэлттэй байна. Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалт жигд бус хуваарилалттай байгааг харуулж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь хэрэгцээ шаардлага, эдийн засгийн үр ашиг багатай олон жижиг арга хэмжээнд чиглэгдсэн байна.

1.6. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн, бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэл, санхүүгийн эх үүсвэр, хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, хариуцах байгууллагыг тусгана" гэж заасан ч эдгээр хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлт байхгүй, хүрэх үр дүн нь ерөнхий байгаагаас тухайн жилд хэрэгжүүлэхээр баталсан ТАХ нь бодлогын баримт бичигтэй уялдахгүй байх нөхцөл болж байна.

1.7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлж эхэлсэн болон 2021 оноос хойш хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй нийцсэн эсэхийг харуулбал:

Хүснэгт 5: ТАХ бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал

ТАХ-ний ангилал	2022 онд шинээр хэрэгжүүлсэн ТАХ			2021 оноос хойш хэрэгжүүлсэн ТАХ		
	Нийцсэн ТАХ-ний тоо	Нийцээгүй ТАХ-ний тоо	Нийт	Нийцсэн ТАХ-ний тоо	Нийцээгүй ТАХ-ний тоо	Нийт
Барилга, байгууламж	317	130	447	462	190	652
Их засвар	33	23	56	40	33	73
Тоног төхөөрөмж	105	34	139	117	40	157
ТЗЗҮ	14	8	22	15	9	24
Дүн	469	195	664	634	272	906
Хувь	70.6%	29.4%		69.9%	30.1%	

Эх сурвалж: Монгол улсын 2022 оны төсвийн тухай хууль, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Дээрх үзүүлэлтээс харахад 2022 онд шинээр хэрэгжүүлсэн ТАХ-ний 29.4 хувь, 2021 оноос хойш хэрэгжүүлсэн ТАХ-ний 30.1 хувь нь бодлогын баримт бичигтэй нийцээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2.5}-д хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ нь "... хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх" гэсэн шаардлагыг хангаагүй байна.

1.8. Дээрх бодлогын баримт бичгүүдээс Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй ТАХ-үүдийн уялдаа хангалтгүй байна. Учир нь:

- Уг хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийн 6.3 хувийг улсын төсвийн хөрөнгө оруулалт эзэлж байна,
- Уг хөтөлбөрт 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ТАХ туссан ба хуулиар батлагдсан 1369 ТАХ-ээс 29 нь 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй байна. Эдгээр 29 ТАХ-ээс 11 нь дээрх хөтөлбөртэй нийцсэн байна.
- Нөгөө талаар хөтөлбөрт 2022 онд хэрэгжүүлэхээр тусгасан нийт 152 ТАХ-ээс 20² нь Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд туссан байна.

1.9. Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт гадаадын зээл, тусламж, концесс, төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх зарим ТАХ-г улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн байна. Тухайлбал:

- Хөтөлбөрт БХБЯ-ны хариуцан хэрэгжүүлэх гадаадын зээл, тусламжийн эх үүсвэртэй зарим ТАХ-г Сангийн сайдын багцын "Гадаадын зээл тусламжаар хэрэгжих төслүүдийн монголын талын хөрөнгө оруулалт" нэртэй ТАХ-ний хүрээнд дараах ТАХ-г санхүүжүүлжээ. Үүнд:
 - Ногоон нуур орчмын 1008 айлын орон сууцны төсөл (2022 онд 4.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн),
 - Солонго-1, 2 орон сууцны хороолол барих төсөл (2022 онд 0.09 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн),
 - Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж (2022 онд 2.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн)
- Хөтөлбөрт ХХААХҮЯ-ны хариуцан хэрэгжүүлэх гадаадын зээл, тусламжийн эх үүсвэртэй зарим ТАХ-г тус сайдын хөрөнгө оруулалтын багцад тусгаж хэрэгжүүлсэн. Үүнд:
 - Бизнес инкубатор төвийн барилга /Ховд, Булган сум/ (2022 онд 1.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн),
 - Орон нутгийн хөгжлийн дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд аймгуудад газар тариалангийн техник хэрэгсэл, малын үүлдрийг сайжруулах чиглэлээр хөрөнгө оруулалт хийгдсэн (2022 онд 9.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн)
- Хөтөлбөрт БОАЖЯ-ны хариуцан хэрэгжүүлэх гадаадын зээл, тусламжийн эх үүсвэртэй зарим ТАХ-г Сангийн сайдын багцын "Гадаадын зээл тусламжаар хэрэгжих төслүүдийн монголын талын хөрөнгө оруулалт" нэртэй ТАХ-ний хүрээнд дараах ТАХ-г санхүүжүүлсэн. Үүнд:
 - Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох 2 дугаар үе шатны төсөл (2022 онд 0.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн),

² Эдгээр 20 ТАХ-ний 11 нь 30 тэрбум төгрөгөөс их, 9 нь бага төсөвт өртөгтэйгээр Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд туссан байна.

Дээрх байдлаас харахад Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд туссан хөрөнгө оруулалтын ТАХ нь Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдаагүй, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт чиглэсэн байна.

1.10. Энэ нь дунд хугацааны бодлогын баримт бичгүүд харилцан уялдаагүй, улсын төсвийн хөрөнгө оруулалт нь хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг дэмжихгүй байгааг харуулж байна.

Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийн ихэнх нь төсөвлөлтийн шаардлага хангахгүй байна.

Магадлал

Барилга байгууламж, их засварын ангилалд шинээр хэрэгжүүлэх 502 ТАХ-ээс 406 нь магадлалгүй батлагдсан байна.

1.11. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэх 664 ТАХ-ээс барилга байгууламж, их засвар ангилалд 502 ТАХ байна. Үүнээс 81 хувь буюу 406 төсөл, арга хэмжээ нь магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй батлагдсан байна. Ангилан харуулбал:

Хүснэгт 6: Магадлалгүй батлагдсан ТАХ-ний тоо

Нийт ТАХ-ний тоо	Үүнээс			Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу.
	Магадлалын хугацаа дууссан	Хууль батлагдсаны дараа магадлал хийсэн	Магадлалгүй	
406	17	287	102	

Эх сурвалж: Барилгын хөгжлийн төвөөс авсан судалгаа

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³, ЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.2.2.2-т "Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх" гэж заасныг зөрчсөн байна.

1.12. ТАХ нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байхад баталж байгаа нь цаашид төсөвт өртөг нэмэгдэх, олон жил үргэлжлэх, төсөв хэмнэх боломжийг алдах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна. Энэ нь тухайн ажлыг хариуцан гүйцэтгэж байгаа албан тушаалтнуудын сахилга хариуцлага сул байгааг харуулж байна.

1.13. Зураг төсөв нь магадлалаар баталгаажуулах ТАХ-г ямар ч тооцоо, судалгаагүй хуулиар баталсныг харуулах дараах жишээ байна. Үүнд:

- ХНХС-ын багцын "Олон улсын Хүүхдийн Найрамдал-2 зуслан" цогцолбор төсөл /Хөвсгөл, Хатгал сум/ ТАХ-а Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд төсөвт өртөгийг 30.0 тэрбум төгрөгөөр тусгасан бөгөөд зураг, төсөв нь магадлалаар 127.8 тэрбум төгрөгөөр баталгаажсан байна. Уг ТАХ тайлант онд зураг, төсөв нь бэлэн болоогүйгээс хэрэгжээгүй.
- ЭХС-ын багцын "Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэсэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн цахилгаан хангамж /Хөвд, Дарви сум/ ТАХ-а Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд төсөвт өртөгийг 5.5 тэрбум төгрөгөөр тусгасан бөгөөд зураг, төсөв нь магадлалаар 25.6 тэрбум төгрөгөөр баталгаажсан.

³ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөвө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

1.14. Магадлалаар баталгаажсан зураг, төсөвгүй ТАХ батлагдаж байгаа нь зарим ТАХ-ний хувьд төсөв хэмнэх боломжийг алдсан байна. Тухайлбал:

- БХБС-ын багцын "Лабораторийн барилга /Дорноговь, Замын-Үүд сум/ ТАХ нь 3.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан ба 2,8 тэрбум төгрөгөөр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна. Харин ТАХ-ний төсөвт өртөг нь магадлалаар 2,7 тэрбум төгрөгөөр баталгаажсан байна. Гэрээний болон магадлалаар баталгаажсан үнийн дүнгийн зөрүү 0.1 тэрбум төгрөг,
 - ЭХС-ын багцын "Мянганы сорилтын сангийн "Улаанбаатар хотын цэвэр усны баруун эх үүсвэрийн төслийн гадна цахилгаан хангамж"-ийн дэд бүтцийн бэлтгэл ажил /Улаанбаатар/ ТАХ нь 5.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан ба 4.9 тэрбум төгрөгөөр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна. Харин ТАХ-ний төсөвт өртөг нь магадлалаар 4.3 тэрбум төгрөгөөр баталгаажсан байна. Гэрээний болон магадлалаар баталгаажсан үнийн дүнгийн зөрүү 0.6 тэрбум төгрөг,
 - ХХААХҮС-ын багцын "Бизнес инкубатор төвийн барилга /Хөвд, Булган сум/ ТАХ нь 4.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан ба 4.6 тэрбум төгрөгөөр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна. Харин ТАХ-ний төсөвт өртөг нь магадлалаар 4.2 тэрбум төгрөгөөр баталгаажсан байна. Гэрээний болон магадлалаар баталгаажсан үнийн дүнгийн зөрүү 0.4 тэрбум төгрөг,
- ХХААХҮЯ-аас "Энэ ТАХ-нд ажлын тоо хэмжээг дутуу тусгасан байсан тул дахин магадлал хийлгэх гэж байгаа" гэсэн тайлбар өгсөн нь ТАХ-ний төлөвлөлтөд хариуцлагагүй ханддагийг илтгэж байна.

1.15. Магадлалаар баталгаажсан зураг, төсөвгүй батлагдсанаас төсөвт өртөг нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл төсөвлөлтийн төлөвлөгөөг алдагдуулж байна. Тухайлбал:

ЭМС-ын багц:

- Вакцины хяналтын лабораторийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ ТАХ-ний төсөвт өртөг 3.5 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд магадлалаар баталгаажсан төсөвт өртөг нь 9.7 тэрбум төгрөг болсон,
- Зооноз өвчин судлалын төвийн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/ ТАХ-ний төсөвт өртөг 2.1 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд магадлалаар баталгаажсан төсөвт өртөг нь 4.4 тэрбум төгрөг болсон,
- Эх хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний төвийн "Хүүхдийн зөвлөх поликлиник"-ийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ ТАХ-ний төсөвт өртөг 17.3 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд магадлалаар баталгаажсан төсөвт өртөг нь 20.6 тэрбум төгрөг болсон.

БШУС-ын багц:

- Дотуур байрны барилга, 160 ор /Дорнод, Баян-Уул сум/ ТАХ-ний төсөвт өртөг 2.9 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд магадлалаар баталгаажсан төсөвт өртөг нь 4.8 тэрбум төгрөг болсон,
- Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 8 дугаар хороо/ ТАХ-ний төсөвт өртөг 9.7 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд магадлалаар баталгаажсан төсөвт өртөг нь 11.1 тэрбум төгрөг болсон байна.

Эдгээр ТАХ-ний магадлалаар баталгаажсан төсөвт гадна шугам сүлжээний төсөв ороогүй байна. Төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулахын тулд гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийг батлуулж, улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.16. Төсөвт өртгийн нэмэгдлийн суурь нь магадлал бөгөөд ТАХ-ний байршил өөрчлөгдөх, барилга байгууламжийн үндсэн хийцлэлд өөрчлөлт орох, төлөвлөсөн хугацаанд ажил эхлээгүй зэрэг шалтгааны улмаас тухайн ТАХ-ний төсөвт өртгийг шинээр магадлах нөхцөл үүсэж байна.

Харин зарим шилжин хэрэгжиж байгаа ТАХ-ний хийж гүйцэтгээгүй ажлын дүнд дахин тооцоолол хийхгүй, шинээр гүйцэтгэхэд шаардагдах төсөвт өртгийн тооцоог гаргаж магадлал хийсэн байна. Энэ нь төсөвт өртгийг үндэслэлгүй нэмэгдүүлж төсвөөс үргүй зардал гарах нөхцөлийг үүсгэсэн байна. Тухайлбал:

Хүснэгт 7: Шилжин хэрэгжиж байгаа ТАХ-нд шинэ ТАХ-тэй адил иж бүрэн магадлал хийсэн байдал /сая төгрөг/

№	ТЕЗ	ТАХ-ний нэр	Хэрэгжих хугацаа	Анхны магадлал хийсэн төсөвт өртөг	Дахин магадлал хийсэн төсөвт өртөг	Зөрүү
1	ХНХС	Сүхбаатар дүүргийн хүүхэд, залуучуудын ногоон бүсийн зуслангийн барилга	2020 – 2022	2,992.9	4,361.1	1,368.2
2	СаС	Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн барилга /Увс, Улаангом сум/	2022 – 2023	1,366.6	2,685.2	1,318.6

Эх сурвалж: ТАХ-ний магадлалын дүгнэлт

ТЭЗҮ

Шинээр хэрэгжүүлэх ТАХ-үүд үр дүнтэй болох нь тогтоогдоогүй батлагдаж байна.

1.17. Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний төсөвлөлтөд "... техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана"⁴ гэсэн шаардлага байгаа ч ТЭЗҮ-г ихэнх төсөл, арга хэмжээнд хийхгүй болсон байна.

1.18. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2.3-д} "техник эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх" гэж заасны дагуу шаардлагатай ТАХ-нд ТЭЗҮ хийнэ гэдэгтэй холбоотой ч ямар ТАХ-г шаардлагатай гэж үзэх нь тодорхойгүй байна.

1.19. Нөгөө талаар Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6-д "эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэхэд үр дүнтэй болох нь урьдчилсан судалгаагаар тогтоогдсон нөхцөлд зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо хийнэ" гэж заасан ч шинээр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнүүдийн эдийн засгийн үр ашиг,

⁴ Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4

нийгмийн ач холбогдлыг Сангийн сайдын баталсан аргачлалын⁵ дагуу үнэн зөв, бодитой тооцохгүй байгаа нь ТЭЗҮ хийгдэхгүй байх нөхцөлийг үүсгэж байна.

1.20. Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлалд 15 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ТАХ-нд зардал, үр ашгийн шинжилгээ хийхээр заасан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа ТАХ-ний ихэнхэд нь уг шинжилгээ хийгдэхээргүй байна. Нийт ТАХ-ний төсөвт өртгийн дүнг харьцуулан харуулбал:

Хүснэгт 8: Нийт ТАХ-нд 15.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ТАХ-ний эзлэх хувь

Нийт ТАХ-ний тоо	15.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ТАХ-ний		2022 онд шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний тоо	15.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ТАХ-ний	
	тоо	Нийт ТАХ-нд эзлэх хувь		тоо	Нийт ТАХ-нд эзлэх хувь
1369	73	5.3	664	35	5.2

Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль

Дээрх мэдээллээс харахад нийт ТАХ-ний 5 хувьд нь зардал, үр ашгийн шинжилгээ хийхээр байна. Гэвч эдгээр ТАХ-нд аргачлалд заасны дагуу шинжилгээ хийгээгүй байна.

1.21. Аргачлалд зааснаар 15.0 тэрбум төгрөгөөс доош төсөвт өртөгтэй ТАХ-нд зардал, үр дүнгийн шинжилгээ болон хамгийн бага зардлын шинжилгээ хийхээр байгаа ч энэ нь нэр төдий буюу шинжилгээг аргачлалын дагуу хийгээгүй байна.

1.22. ТАХ-нд эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож байгаа шинжилгээний үр дүнгээс харахад хэрэгжүүлж байгаа ТАХ-үүд үр дүнтэй болох нь тогтоогдохгүй байна. Тодруулбал:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем www.pimis.publicinvestment.gov.mn цахим хуудсанд ТЕЗ-дын байршуулсан ТАХ-ний төлөвлөлтийн мэдээлэл нь (хүснэгтэн болон асуултуудад харуулт өгсөн мэдээлэл, зарим ТАХ-нд огт байхгүй) бодитой тооцоо судалгаагүй, үндэслэл нь тодорхойгүй, үр дүнг үнэлж тогтоогоогүй байна.

ТАХ-ний төлөвлөлтийн гол үзүүлэлт болох эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэн зөв, бодитой тооцоогүй, улмаар ТЭЗҮ-г орхиуулж байгаа нь хэрэгцээ, шаардлагаас давсан хөрөнгө оруулалт хийгдэх, төсөвт ачаалал нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагаврыг үүсгэхээр байна.

1.23. Мөн шинээр хэрэгжүүлж байгаа ТАХ-ний үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой зардлын тооцоог бүрэн тооцдоггүй, төсөвт нөлөөлөх ачааллын дүгнэлтийг огт гаргаагүй байна.

1.24. Хөрөнгө оруулалтын төсөвлөлтөд хуулийн шаардлага хангаагүй ТАХ тусч байгаа нь ТЕЗ-ийн хүргүүлсэн ТАХ-ний санал УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд өөрчлөгдөж батлагддагтай холбоотой ч ТАХ хэрэгжиж байгаа нэгжээс ТЕЗ хүртэлх ажлын уялдаа холбоо хангалтгүй, нэн тэргүүнд шаардлагатай ТАХ-г зөв тодорхойлоогүй, нэгдсэн судалгаагүйг харуулж байна.

⁵ Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал", Үндэсний хөгжлийн газрын даргын (хуучин нэрээр) 2020 оны А-56 дугаар тушаалаар баталсан "Төслийн эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийх аргачлал"

Эрэмбэлэгдээгүй

УИХ-аар хэлэлцүүлэх шатанд нэмэгдсэн барилга байгууламж, их засвар төсөвлөлтийн шаардлага хангахгүй байна.

1.25. Шинээр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ, УИХ-аар хэлэлцүүлэх шатанд нэмэгдсэн ТАХ-ний мэдээллийг харьцуулан харуулбал:

Хүснэгт 9: УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд нэмэгдсэн ТАХ-ний мэдээлэл

Нийт ТАХ-ний тоо	2022 онд шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний тоо	УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд нэмэгдсэн ТАХ-ний	
		тоо	Шинэ ТАХ-нд эзлэх хувь
1369	664	104	15.6

Шинээр хэрэгжүүлж буй ТАХ-ний 15.6 хувь нь УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд нэмэгдсэн байна.

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн мэдээлэл

УИХ-аар хэлэлцүүлэх шатанд нэмэгдсэн 104 ТАХ-ний 71 нь барилга байгууламж, их засвар бөгөөд эдгээр нь хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.

1.26. Орон нутгийн ТЕЗ-аас СаЯ-нд хүргүүлсэн "Улсын төсвийн төсөвт тусгуулах хөрөнгө оруулалтын ТАХ-ний санал" нь хуульд тусгахдаа өөрчлөгдөж байна. Тухайлбал:

- Дорнод аймгийн Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 1/844 тоот албан бичгээр улсын төсөвт тусгуулах хөрөнгө оруулалтын ТАХ-г хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлэн 31 ТАХ-ний саналыг СаЯ-нд хүргүүлсэн байна. Гэтэл эдгээр ТАХ-ээс Монгол Улсын 2022 оны улсын төсвийн тухай хуульд 4 нь туссан,
- Баянхонгор аймгийн Засаг дарга улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх 34 ТАХ-г хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлэн саналыг СаЯ-нд хүргүүлсэн байна. Гэтэл эдгээр ТАХ-ээс Монгол Улсын 2022 оны улсын төсвийн тухай хуульд 4 нь туссан байна. Харин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, ТЕЗ-ийн саналд үндэслээгүй 19.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 8 ТАХ-ний эрхийг шилжүүлсэн байна.

1.27. УИХ-аар хэлэлцүүлэх шатанд нэмэгдэж байгаа ТАХ-үүд төсөвлөлтийн шаардлага хангахгүй байх нь түгээмэл ч тухайн жилийн төсвийн тухай хуульд "Улсын хэмжээнд гэж нэрлэсэн болон нэгээс дээш ТАХ-г нийлүүлэн нэг ТАХ болгон" баталсан ТАХ-үүд хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн шаардлага хангахгүй байна.

1.28. "Улсын хэмжээнд гэж нэрлэсэн болон нэгээс дээш ТАХ-г нийлүүлэн нэг ТАХ болгон" баталсан ТАХ салбарын сайдын тушаалаар хэд болон задарсныг зураглалаар харуулбал:

Дүрслэл 1: ТАХ-ний задарсан тоо



Эх сурвалж: ТЕЗ-ийн ТАХ-г задарсан тушаал

Нийт ТАХ-ээс 126 нь 1040 болж задарсан байна.

Задарсан 126 ТАХ-ний төсөвт өртөг нь 1,410.6 тэрбум төгрөг буюу нийт ТАХ-ний төсөвт өртгийн 22.9 хувийг эзэлж байна.

Өөрөөр хэлбэл нийт ТАХ-ний төсөвт өртгийн ¼ -г ТЕЗ-чид хууль батлахтай адил хуваарилж байна.

1.29. Задарсан ТАХ-г жишээгээр харуулбал:

БХБС-ын багцын "Аймгуудын шинэ суурьшлын бүсэд баригдах орон сууцны хорооллын шугам сүлжээ, дэд бүтэц /Улсын хэмжээнд/" ТАХ-ний төсөвт өртөг нь 100.0 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 13.7 тэрбум бөгөөд нийт 22 ТАХ-нд задарсан байна.

Хүснэгт 10: Задарсан ТАХ-ний ажлын гүйцэтгэл /сая төгрөг/

Аймгуудын шинэ суурьшлын бүсэд баригдах орон сууцны хорооллын шугам сүлжээ, дэд бүтэц /Улсын хэмжээнд/	Задарсан ТАХ-ний нэр		Төсөвт өртөг	Ажлын гүйцэтгэл	
	Хувиар	Үнийн дүнгээр		Хувиар	Үнийн дүнгээр
Ф720 мм-ийн дулааны төв шугам сүлжээний өргөтгөлийн ажил /Орхон, Баян-Өндөр сум/	4,340.0	54	2,323.08		
Төв дулааны цэвэр усны шугам, ус дулаан дамжуулах төвийн барилга, гадна инженерийн шугам сүлжээний ажил /Орхон, Баян-Өндөр сум, Их залуу баг/	1,370.0	74	1,008.4		
Төв дулаан, цэвэр усны шугам сүлжээний өргөтгөл, ус дулаан дамжуулах төв барих ажил /Орхон, Баян-Өндөр сум, Цагаан чулуут, Наран баг/	4,330.0	53.7	2,325.19		
Эрх чөлөөний гудамжны уулзварын өргөтгөлийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт /Орхон, Баян-Өндөр сум, Уурхайчин баг/	2,000.0	14	274.0		
Ариутгах татуургын 3-р коллекторын төв шугам татах ажил /Орхон, Баян-Өндөр сум/	20,000.0	52.6	10,503.3		
Залуус-1 хорооллын дулаан хангамжийн ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/	14,502.0	0			
Залуус-1 хорооллын ус дулаан дамжуулах төв барих ажил 8 ширхэг /Дархан-Уул аймаг, Дархан сум/	5,755.6	0			
Залуус-1 хорооллын цэвэр, бохир усны шугамын ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/	4,071.0	0			
Залуус-1 хорооллын цахилгаан хангамжийн ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/	2,099.7	0			
Залуус-1,2 хорооллын холбоо дохиоллын ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/	1,265.3	0			
Залуус-2 хорооллын дулаан хангамжийн ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/	6,848.6	0			
Залуус-2 хорооллын ус дулаан дамжуулах төв барих ажил 2 ширхэг /Дархан-Уул аймаг, Дархан сум/	1,438.9	0			
Залуус-2 хорооллын цэвэр, бохир усны шугамын ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/	2,410.7	0			
Залуус-2 хорооллын цэвэр усны усан сан 500м3 барих ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/	481.0	0			
Залуус-2 хорооллын цахилгаан хангамжийн ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/	8,654.4	14.92	1,185.7		
Шинэ суурьшлын бүсийн орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээний ажил /Төв, Зуун мод сум/	9,396.0	0		ажил хийгдээгүй	
Орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээний ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	701.4	14	96.1		
"Мандал хороолол"-ын гадна шугам сүлжээ, халаалтын зуухны барилга угсралтын ажил /Дундговь, Сайнцагаан/	500.0	0		ажил хийгдээгүй	
"Түмний хороолол" болон "Хаус хороолол"-ын гадна 2.0 км ариутгах татуургын шугам сүлжээний ажил /Дундговь, Сайнцагаан/	800.0	0		ажил хийгдээгүй	
21-р зуун жишиг хорооллын шинээр хийгдсэн шугамыг төвлөрсөн шугам сүлжээнд холбох /Завхан, Улиастай/	2,900.0	0		ажил хийгдээгүй	
Орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээний ажил /Сүхбаатар, Баруун-Урт сум/	3,000.0	23.92	686.38		
Гадна дулаан хангамж, цэвэр усны шугамын ажил /756 м /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 4, 8-р баг/	2,131.7	44.9	942.0		

Эх сурвалж: БХБС-ын тушаал, ажлын гүйцэтгэлийн баримт

Эдгээр ТАХ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, ЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.2.2.2-г заасан шаардлагыг хангаагүй байна. ТАХ-үүдийн ажлын гүйцэтгэлээс харахад ихэнх нь ажил хийгдээгүй, үр дүн хангалтгүй байна.

1.30. СаС-ын багцын улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-үүд нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна. Тухайлбал:

- "Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах /Улсын хэмжээнд/" ТАХ 8.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, барилга байгууламжийн ангилалд баглагдсан ч их засвар, тоног

төхөөрөмж, ТЭЗУ-ийн ажлууд хийгдсэн байна. Энэ нь ЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.1.33⁶-г зөрчсөн байна.

- "Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/" ТАХ-ний хүрээнд хэрэгжүүлж байгаа ТАХ-үүд мэдээлэл нь тодорхойгүй байна. Тодруулбал: Тухайн ТАХ-нд Монголын талын хариуцаж байгаа нийт хөрөнгө оруулалтын дүн, ямар хугацаанд хэрэгжих нь тодорхойгүй байдлаар батлагдаж байна.

Олон жил үргэлжилсэн

ТАХ-г анх баталсан хугацаанд дуусгаагүйгээс 17.2 тэрбум төгрөгийн үргүй зардал гарахаар болсон байна.

1.31. Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд туссан хөрөнгө оруулалтын ТАХ-ээс 6-11 жил үргэлжилж байгаа нийт 29 ТАХ байна. Эдгээр ТАХ-ний мэдээллийг харуулбал:

Хүснэгт 11: 6-11 жил үргэлжилж байгаа ТАХ /тэрбум төгрөг/

№	ТЕЗ	ТАХ-ний тоо	Анхны төсөвт өртөг	2022 оны төсөвт өртөг		Зөрүү
				Дүн	Анх хэрэгжиж дуусах байсан хугацааны үнэ цэнэ	
1	БХБС	1	3	4	5	6=5-3
		2	18.7	29.1	15.8	-2.9
2	БШУС	1	5.0	5.0		
		1	4.0	8.0	4.5	0.5
3	ЗГХЭГД	4	8.9	11.4	6.5	-2.4
		1		12.9		
4	ЗТХС	2	3.0	12.2	5.5	2.5
		1	3.2	9.1	3.3	0.1
5	МУЕС	1	1.2	1.2		
		1	0.5	0.5		
6	СоС	1	11.0	27.1	9.8	-1.2
		5	14.6	57.8	23.5	8.9
7	ЭХС	4	20.9	33.8	19.1	-1.8
		3	11.6	38.9	16.9	5.3
		1	14.5	16.9	9.8	-4.7
		Нийт	29			17.3

Эдгээр ТАХ-ээс зарим ТАХ-ний мэдээлэл МУ-ын 2022 оны төсвийн тухай хуульд алдаатай туссан байна. Тухайлбал:

- ЗГХЭГД-ын багцын "Сумын Засаг даргын Тамгын газрын барилга /Завхан, Тэс сум/ ТАХ-ний хугацаа 2013 – 2022 он гэж туссан ч уг ТАХ анх 2018 оны хуульд 2013 оноос эхэлсэн гэж туссан байна.
- ТАХ-ний эхлэх хугацааг 1 жилээр зөрүүтэй тусгасан нийт 7 ТАХ байна.
- БШУС-ын багцад 2015 – 2023 он гэсэн хугацаатай 1 ТАХ, ЗТХС-ын багцад 2017 – 2023 он гэсэн хугацаатай 1 ТАХ 2022 онд анх хуульд туссан байна.

Эх сурвалж: Аудиторын шинжилгээний үр дүн

Дээрх мэдээллээс харахад дараах нөхцөл байдал үүсэж байна. Үүнд:

- 2022 оны төсвийн тухай хуульд туссан олон жил хэрэгжиж байгаа ТАХ-ний төсөвт өртгийн өнөөгийн үнэ цэнийг тооцон гаргаж анхны төсөвт өртөгтэй харьцуулахад зарим нь хасах утгатай, зарим нь нэмэх утгатай, зарим нь огт өөрчлөгдөөгүй байна. Энэ нь ТАХ-ний хэрэгжих хугацаа удааширсантай холбоотой төсөвт өртгийн өсөлт нь жигд биш байна. Өөрөөр хэлбэл бодитой бус, зарим ТАХ-ний төсөвт өртөг хэт өсөлттэй байгааг харуулж байна.

⁶ Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно.

Үүнээс нэмэх утгатай ТАХ-г анх баталсан хугацаанд хэрэгжүүлээгүйгээс төсвөөс нийт 17.3 тэрбум төгрөгийн үргүй зардал гарахаар болсон байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу) Одоогийн байдлаар нийт 200.5 тэрбум төгрөг олгосон байна.

1.32. Олон жил үргэлжилж байгаа дээрх ТАХ-ээс харахад ихэнх нь боловсрол, соёл, спортын салбарын барилга байгууламж байгаа бөгөөд эдгээр салбарын харьяалал нь олон удаа солигдсоноос ТАХ удаашрах нэг нөхцөл болсон байна. Тодруулбал: Спорт, аялал жуулчлалын яам, Эрүүл мэнд, спортын яам, Боловсрол Соёл Спортын яам гэх байдлаар өөрчлөгдсөн байна.

Орхигдсон ТАХ

Зарим дуусаагүй ТАХ хуульд тусаагүй орхигдсон байна.

1.33. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ ялангуяа барилга, байгууламжид төлөвлөлтийн үе шатнаас эхлэн ашиглалтын хугацаа дуусах хүртэлх хугацаанд хяналт тавих нэгдсэн систем, цахим сан байхгүйгээс төсөл, арга хэмжээ дутуу орхигдох, хаягдах, зарцуулсан хөрөнгө үргүйдэх байдал ажиглагдаж байна. Тодруулбал:

- Нийт 10 ТЕЗ-чид хамаарах 2011 – 2021 онд эхэлсэн, 120.0 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй, 87.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон 54 ТАХ байна. Эдгээр ТАХ-ний ажлын гүйцэтгэлийн дундаж 53 хувьтай байна. (ТАХ-ний мэдээллийг хавсралт 3-аас харна уу)

Эдгээр ТАХ-ний хэрэгжилтийг үнэлж цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх эсвэл зогсоох талаар шийдвэр гаргаж, зогсоосон нөхцөлд буруутай этгээдэд хариуцлага тооцох шаардлагатай байна.

БҮЛЭГ 2: ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ОНОВЧТОЙ ХУВААРИЛААГҮЙ БАЙНА.

Магадлалаар баталгаажсан зураг, төсөвгүй худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа нь шалгарсан компанид давуу байдал олгож, худалдан авах ажиллагааны зарчмыг алдагдуулж байна

2.1. Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан нийт 664 ТАХ-ний ХАА-ны мэдээллийг харуулбал:

Хүснэгт 12: Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний ХАА-ны мэдээлэл /тэрбум төгрөг/

ТАХ-ний тоо	1-3 удаа тендер зарласан ТАХ-ний Тоо		4-өөс дээш удаа тендер зарласан ТАХ-ний Тоо		ХАА зохион байгуулаагүй байгуулаагүй Тоо		ХАА хүчингүй болсон ТАХ-ний Тоо		
	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Сүүлийн хугацаа	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Төсөвт өртөг	
664	597	2,415.1	62	2022.12.26	515.0	5	27.4	19	261.1

Эх сурвалж: ТЕЗ-дын ХАА-ны баримт

Дээрх мэдээллээс харахад шинээр хэрэгжүүлж байгаа нийт ТАХ-ний 10 хувь нь буюу 67 ТАХ хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна. Мөн 19 ТАХ-ний ХАА зохион байгуулагдсан ч хүчингүй болсон байна. (ТАХ-ний жагсаалтыг хавсралт 4-өөс харна уу)

2.2. ХАА удааширч олон удаа тендер зарлаж хугацаа алдаж байгаад дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Тухайлбал:

- Үнэлгээний хорооны гишүүд тендер оролцогчдод хэт өндөр шалгуур тавьж буй нь ХАА-г дахин дахин хүчингүй болгож байна. Энэ нөхцөлд үнэлгээний хорооны гишүүд тендерийн баримт бичигт заасан шалгуурыг ямар нэгэн шалгуургүйгээр өөрчилж (бууруулдаг) гүйцэтгэчийг сонгон шалгаруулдаг.
Тодруулбал: Тухайн барилга байгууламжийг гүйцэтгэх ААН-д зөвлөх инженер шаардлагатай гэж шалгуур тогтоон гүйцэтгэгч оролцохгүй тохиолдолд үнэлгээний хороо шалгуурыг "мэргэшсэн инженер болгоё" гэх байдлаар шийдэж байгаа нь тендерийн шалгуур үзүүлэлтийг бодитой тогтоодоггүйг илтгэж байна.
- Захиалагч юу хэрэгтэй байгаагаа зөв тодорхойлдоггүй, өртгийн тооцооллыг бодитой тооцоогүйгээс тендер амжилтгүй болох үед ажлын даалгаврыг өөрчилж дахин тендер зарладаг.
Жишээ нь: ХХААХҮС-ын багцын "Зоорь, хүлэмжийн байгууламж, 1000 тонн /Сэлэнгэ, Зүүнбүрэн сум", ТАХ-ний (Төсөвт өртөг 1.0 тэрбум төгрөг) ХАА-ны үр дүнд гүйцэтгэгч шалгараагүй бөгөөд ажлын даалгаврыг өөрчилж ТАХ-г хэрэгжүүлсэн байна. Үүний үр дүнд зоорийн байгууламж хийгдэхгүй болсон.

2.3. Нөгөө талаар төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу зураг, төсөлгүй, ажлын тоо хэмжээ дутуу ТАХ-ний тендерийг зарласан нь хугацаандаа хэрэгжих боломжгүй болж, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг үүсгэж байна. Тухайлбал:

БШУС-ын багцад:

- Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, Сэтгэмж сургууль /2018-2022/, ТАХ-ний төсөвт өртөг 3.2 тэрбум төгрөг бөгөөд гүйцэтгэгч "Грийн ресурс" ХХК 2.8 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр 2018 онд гэрээ байгуулсан байна. 2021, 2022 онд 4 удаагийн магадлалаар нэмэлт гэрээ байгуулж нийт 1.9 тэрбум төгрөгөөр төсөвт өртөг нэмэгдэн 4.7 тэрбум төгрөг болсон байна. Гэтэл Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд төсөвт өртөг нь 5.7 тэрбум төгрөгөөр туссан байна. Одоогийн байдлаар гүйцэтгэгчид 4.7 тэрбум төгрөг олгосон байна.
- Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 13 дугаар хороо/ ТАХ-ний төсөвт өртөг-7.8 тэрбум төгрөг бөгөөд түлхүүр гардуулах нөхцөлтэй тендер зарлаж "Тэргүүн чансаа" ХХК шалгарч 7.7 тэрбум төгрөгөөр гэрээ байгуулсан байна.
Гүйцэтгэгч компани зураг төсөл боловсруулан магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг 1.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж бодит өртөг 9.2 тэрбум төгрөг болсон ба гэрээний үнийг магадлалын дүнгээр байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална" гэж заасныг зөрчсөн тул тендерийн хэмнэлт болох 0.05 тэрбум төгрөгийг хасаж тооцон, гэрээг өөрчилж байгуулах албан шаардлага хүргүүлэв.

МУЕС-ын багцад:

- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Соёл, спорт цогцолборын барилгын ажил 2019 онд улсын төсөвт 6.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдаж гүйцэтгэгчтэй 5.8 тэрбум төгрөгөөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Тус онд төсөвт өртөг 6.3 тэрбум төгрөг болж магадлалаар баталгаажсан ч гадна инженерийн шугам сүлжээний ажил орхигдсон байна. Гадна инженерийн

шугам сүлжээний ажил 2021 онд магадлалаар 3.8 тэрбум төгрөгөөр баталгаажсан байна. Уг ажлыг гүйцэтгэгчтэй нэмэлтээр шууд гэрээ байгуулсан байна.

2.4. Зураг, төсөвгүй ТАХ-ний ХАА-г зарласны үр дүнд дараах сөрөг нөлөөлөл бий болж байна. Тухайлбал:

- ХАА-ны үр дүнд тендерийн хэмнэлт бий болсон ч магадлалаар төсөвт өртөг нэмэгдэхэд уг дүнгээр гэрээ байгуулж байгаа нь тухайн гүйцэтгэгчид давуу байдал үүсгэж, өрсөлдөөнийг хязгаарлаж, ХАА-г үр дүнгүй болгож байна. Нөгөө талаар гүйцэтгэгчийг "тендерт ямар ч хамаагүй үнээр шалгарч дараа нь нэмэлт гэрээ байгуулна" гэсэн хандлагад хөтөлж байна.
Жишээ нь: Соёлын сайдын багцын Музейн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/-ын ХАА-г 5.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр зарлаж гүйцэтгэгч 4.9 тэрбум төгрөгийн үнийн саналаар шалгарсан байна. Гэтэл магадлалаар төсөвт өртөг нь 5.9 тэрбум төгрөгөөр баталгаажуулсан бөгөөд нэмэлт санхүүжилтийн гэрээг 5.9 тэрбум төгрөгөөр байгуулсан байна.

2.5. Мөн түлхүүр гардуулах гэрээний⁷ нөхцөлөөр ХАА зарлаж байгаа нь ТАХ-ний төсөвт өртөг нэмэгдэх нөхцөлийг үүсгэж байна. Тодруулбал:

Уг нөхцөлөөр тендер зарлаж байгаагаас ТАХ-ний гүйцэтгэгч нь зураг, төсөв зохиогчийн хувьд захиалагч болж байна. Энэ нь зураг, төсөв зохиогч Барилгын тухай хуулийн 3.1.6⁸, 3.1.8⁹, Барилга хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалын хавсралт "Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм"-ийн 4.1-д заасан эрх, чиг үүргийг хараат бусаар хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж, Барилгын тухай хуулийн 3 дугаар зүйл 3.1.2¹⁰ заасан барилгын үйл ажиллагаанд оролцогч зураг төсөл зохиогч, барилгын ажил гүйцэтгэгчийн хооронд эрх тэгш, бие даасан байдлыг хангах зарчмыг алдагдуулж байна.

Ингэснээр барилга угсралтын ажил гүйцэтгэгч нь зураг төсөв зохиогчид барилгын ажлын зураг төсөлд хөндлөнгийн хяналтгүйгээр өөрчлөлт оруулж дахин магадлал хийлгэн төслийн нийт төсөвт өртгийг нэмэгдүүлэх нөхцөл байдлыг үүсгэж байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29¹ дүгээр зүйлийн 29².2 дах заалттай зөрчилдөж байгаа тул түлхүүр гардуулах гэрээний нөхцөлөөр ХАА зохион байгуулах тухай хуулийн зохицуулалтыг¹¹ хүчингүй болгох нь зүйтэй байна.

2.6. ЭМС-ын багцад 2022 онд шинээр хэрэгжүүлэх 5, шилжин хэрэгжиж байгаа 1 нийт 42.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 ТАХ-ний ажлын тоо хэмжээг хувааж тендер зарласан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.4-т "Худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах" гэж заасныг зөрчсөн байна.

⁷ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 5.1.6, 8.10

⁸ БТХ 38.1.6.Барилга байгууламжийн зураг төсөлд өөрчлөлт оруулах захиалагчийн санал барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт тавих чанар, аюулгүй байдлын шаардлагад нийцсэн тохиолдолд зөвшөөрч, баталгаажуулах;

⁹ БТХ 38.1.8.Барилгын ажилд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авахыг захиалагчаас шаардах;

¹⁰ БТХ 3.1.2.Барилгын үйл ажиллагаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдлыг хангах.

¹¹ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.16, 8 дугаар зүйлийн 8.10 дах заалт

Ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээнүүдийн санхүүжилтийн шийдвэрлэлт хангалтгүйгээс цаашид ТАХ зогсох, үр ашиггүй болох, өртөг нэмэгдэх эрсдэл үүсгэж байна.

2.7. Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар баталсан нийт 1369 ТАХ-ний гүйцэтгэлийн мэдээллийг харуулбал:

Хүснэгт 13: ТАХ-ний ажлын гүйцэтгэл

ТАХ-ний ангилал	ТАХ-ний тоо	ТАХ-ний гүйцэтгэлийн хувь	Бүрэн хэрэгжсэн ТАХ-ний тоо
Барилга, байгууламж	1062	59.1	321
Их засвар	108	71.8	58
Тоног төхөөрөмж	170	75.6	106
ТЭЗҮ	29	60.2	10
Нийт	1369	62.2	495

Эх сурвалж: ТЭЗ-ийн ТАХ-ний ажлын гүйцэтгэлийн баримт

2022 онд хэрэгжсэн ажлын гүйцэтгэлийг салбараар ангилан харуулбал:



Шинээр барих болон шинэчлэх цэвэр усны шугам сүлжээ – 66.97 км
Шинээр барих болон шинэчлэх бохир усны шугам сүлжээ – 76.8 км
Шинээр барих болон шинэчлэх дулааны шугам сүлжээ – 30.3 км
Шинээр барих болон шинэчлэх ЦДАШ – 483.27 км
Шинээр барих үерийн барилга, байгууламж, далан суваг – 19.3 км
Авто зам - 169 км
Гүүр - 517.4 ү/м



Худаг, уст цаг - 13
Газар тариалангийн то/тех - 64 иж бүрдэл, 116 хүлэмж
Мал аж ахуй - 1300 үржлийн мал
Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж - 8га
Нуур, цөөрөм хамгаалал - 16.7 км ус дамжуулах шуудуу, далан



Гаалийн шинэчлэл – Гаалийн төв болон салбар лабораторид нийт 182 то/тех
Татварын шинэчлэл - 3 багц то/тех



Эмнэлгийн барилга - 18
Хүүхэд залуучууд, иргэдийн төв 2
Ахмадын төв, сувилал - 3



Спорт цогцолбор - 12
Соёлын төв - 14
Сургуулийн барилга - 37
Цэцэрлэгийн барилга - 63
Дотуур байр - 13



Мэдээллийн технологи - 40 суманд хөдөлгөөнт холбоо, 25 суманд холбооны дэд бүтэц
Шинжлэх ухааны тоног төхөөрөмж - 1 багц

Дээрх ангилалд 2022 онд зарцуулсан санхүүжилтийн дүнг харуулбал:

Хүснэгт 14: Салбаруудад зарцуулсан санхүүжилтийн мэдээлэл /тэрбум төгрөг/

Ангилал	ТАХ-ний тоо	Санхүүжилтийн дүн	Нийт санхүүжилтийн дүнд эзлэх хувь
Дэд бүтэц	293	408.9	33
Санхүү, эдийн засаг	41	33.7	2.7

Нийт ТАХ-ний ажлын гүйцэтгэл дунджаар 62.2 хувьтай байна. Үүнээс 2022 онд нийт 495 ТАХ бүрэн хэрэгжсэн байна.

Соёл, спорт, боловсрол	557	373.2	30.1
Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	147	97.9	7.9
Шинжлэх ухаан, мэдээллийн технологи	17	26.5	2.1
Хөдөө аж ахуй, байгаль орчин	135	61.1	4.9
Төрийн байгууллагын албан хэрэгцээ	110	118.2	9.5
Төрийн өмчлөлд шилжих боломжгүй	33	17.8	1.5
Бусад	36	100.8	8.3
Нийт	1369	1,238.1	100

Дэд бүтэц, санхүү, эдийн засаг, шинжлэх ухаан, мэдээллийн технологийн салбарт нийт санхүүжилтийн 37.8 хувийг зарцуулсан байна.

Эх сурвалж: Сангийн яамны санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээ

Дээрх үзүүлэлтээс харахад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсвийг тэлсэн, нийгмийн ач холбогдолд чиглэсэн ТАХ-г түлхүү хэрэгжүүлж байна.

2.8. Нөгөө талаар улсын төсвийн хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөө үзүүлж байгааг дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулан харуулбал:

Дүрслэл 2: УТХО-н Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын дүн болон ДНБ-нд эзлэх хувь /тэрбум төгрөг/



Эх сурвалж: 1212.тп, Сангийн яамнаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн мэдээ

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг ДНБ-ний өөрчлөлттэй харьцуулан хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцоход дараах байдалтай байна.

Хүснэгт 15: Улсын төсвийн хөрөнгө оруулалт, түүний үр ашиг /тэрбум төгрөг/

Он	Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл	Хөрөнгө оруулалт ¹² /зэрэгцүүлэх үнээр/	ДНБ /2015 оны зэрэгцүүлэх үнээр/	ДНБ-ний өөрчлөлт	Хөрөнгө оруулалтын үр ашиг (НХГХ) ¹³	Улсын нийт хөрөнгө оруулалтын гүйцэтгэл	Улсын нийт хөрөнгө оруулалтын үр ашиг (НХГХ)
A	1	2	3	4	5=2/4	6	7
2020	1,414.6	1,107.1	26,655.3	-1,272.9	-0.87	17,162.3	-10.55
2021	1,577.7	1,169.7	27,091.6	436.3	2.68	15,869.0	26.97
2022	1,238.1	789.4	28,404.5	1,312.9	0.6	17,014.3	8.26

Эх сурвалж: 1212.тп, Сангийн яамнаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн мэдээ

¹² Хөрөнгө оруулалтыг зэрэгцүүлэх үнд шилжүүлэхэд хөрөнгийн нийт хуримтлалын 2015 оны суурьтай дефляторыг ашигласан болно.

¹³ Хөрөнгө оруулалтын үр ашиг (НХГХ) -н утга бага байх тусам өндөр үр ашигтай гэж үзнэ.

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын дүн өмнөх оноос буурсан үзүүлэлттэй ч улсын нийт хөрөнгө оруулалтын дүн өссөн байна. Дээрх үзүүлэлтээс ДНБ-ийг нэгжээр нэмэгдүүлэхэд хэдий хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдсаныг авч үзвэл:

ДНБ-ийг 100 төгрөгөөр нэмэгдүүлэхэд 826 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн ба үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалт 60 төгрөг буюу 7 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл ДНБ-ний өсөлтөд улсын төсвөөс бусад хөрөнгө оруулалт дийлэнх хувийг эзэлж байна. Улсын нийт хөрөнгө оруулалтын үр ашиг өмнөх онтой харьцуулахад дээшилсэн байна.

Иймд дэд бүтэц, эдийн засгийн үр өгөөжийг дэмжих ТАХ-ний хувь хэмжээг бодлогоор нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2.9. Хэрэгжээгүй болон хэрэгжилт дутуу байгаа 874¹⁴ ТАХ-ний 56 нь хэрэгжээгүй, 818 нь хэрэгжилт дутуу байна. Үүнээс 428 нь ажил гүйцэтгэх гэрээний хугацаа болоогүй байна. Хэрэгжээгүй болон хэрэгжилт дутуу ТАХ-ний шалтгааныг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 16: Хэрэгжилт дутуу ТАХ-ний мэдээлэл /тэрбум төгрөг/

№	Ангилал	ТАХ-ний тоо	ТАХ-ний төсөвт өртөг
1	Санхүүжилт хугацаандаа олгогдоогүйгээс	17	83.87
2	Зураг, төсөвт өөрчлөлт орж дахин магадлал хийлгэснээс	37	74.21
3	Захиалагчийн үйл ажиллагаанаас	47	157.76
4	Гэрээний хугацаанд хэрэгжүүлэх боломжгүйгээс	12	28.06
5	Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас	72	315.32
6	Гадна инженерийн дэд бүтэц шийдэгдээгүйгээс	17	66.71
7	Бусад	188	1,192.65
Нийт		390	1,918.58

Эх сурвалж: ТАХ-ний судалгааны нэгтгэл

Хүснэгт 17: Хэрэгжээгүй ТАХ-ний мэдээлэл /тэрбум төгрөг/

№	Ангилал	ТАХ-ний тоо	ТАХ-ний төсөвт өртөг
1	ХАА хүчингүй болсон	22	283.88
2	ХАА хийгдсэн боловч ажил 2023 онд эхэлнэ	6	12.25
3	ХАА зохион байгуулагдаагүй	6	27.82
4	Гүйцэтгэгч ажлаа хугацаанд нь хийгээгүй	1	4.10
5	Газрын зөвшөөрөлгүй	3	5.09
6	Бусад	18	67.31
Нийт		56	400.45

Эх сурвалж: ТАХ-ний судалгааны нэгтгэл

Хэрэгжээгүй ТАХ-ний дэлгэрэнгүй мэдээллийг **хавсралт 5-аас** харна уу.

Ач холбогдол бүхий төсөл

Чухал ач холбогдол бүхий төслүүдийн санхүүжилтийн шийдвэрлэлт удаашралтай байгаагаас үр өгөөж нь хойшилж, эрсдэлд хүргэж болзошгүй байна.

2.10. БХБС-ын багцын "Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г, д Ø800-ийн гол шугамыг Ø1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөв, барилга угсралтын ажил" ТАХ нь

¹⁴ Хэрэгжээгүй ТАХ 56, хэрэгжилт дутуу ТАХ 812 болно.

хотын дулаан хангамжийн чухал¹⁵ ажил хэдий ч дараах асуудлуудаас шалтгаалж удаашралтай, цаашид төсвөөс үргүй зардал гарах нөхцөлийг бий болгосон байна. Тухайлбал:

- ТАХ-ний гүйцэтгэгчийг 2014 онд шалгаруулсан ч гэрээ байгуулж ажлыг эхлүүлэхэд хугацаа их алдсан буюу 2017 онд гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн.
- Санхүүжилтийг шийдвэрлэх асуудал хангалтгүй байгаагаас уг ТАХ олон жил үргэлжлэх нөхцөл бүрдэж байна. ТАХ-ний төсөвт өртөг 24.9 тэрбум хэдий ч олгосон санхүүжилт нь 4.2 тэрбум байна. Үүний үр дүнд 3.4 км урттай шугамын ажлаас 0.49 км нь хийгдсэн байна.

40 жил ашигласан шугам

Ханын материал, Баянхошуу орчим, Хархорин зах, Эрин, Өнөр хороолол орчим, 1, 3, 4, 10 дугаар хороолол, хотын төвийн хэсэг болох Цирк, Баянгол гол зочид буудал, МУБИСургууль, Усан бассейны, ШУТИС орчмын хэрэглэгчид мөн XII хороолол Сансар Мамба дацан орчим, XIII хорооллын хойд хэсэг, XV хороолол орчмын хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангадаг гол магистраль шугам

Дээрх нөхцөл байдалд "Уг ТАХ-г ЭХС-ын багцад бус БХБС-ын багцад тусгаж, улмаар нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлж" байгаа нь ихээхэн нөлөөлж байна.

ТАХ-ний чиглэлд олон бүтээн байгуулалт хийгдэж байгаа нь цаашид ТАХ удаашрах тусам улам хүндрэлтэй нөхцөл байдалтай тулгарах эрсдэлтэй байна.

Нөгөө талаар ТАХ-тэй хамтад нь хэрэгжүүлэх шаардлагатай бусад ТАХ-ний санхүүжилтийг шийдвэрлэхгүй байгаа нь дахин дахин үргүй зардал ихээр гарах нөхцөлийг үүсгэж байна. **Тодруулбал:** Уг ТАХ-тэй хамт цэвэр, бохир усны шугам хийгдэх хэдий ч энэ асуудал орхигдсон, тус асуудлыг хариуцсан газрууд хариуцлагатай хандаагүй байна. Энэ нь холбогдох газруудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, холбогдох стандарт, норм, дүрмийн дагуу ажлыг төлөвлөж гүйцэтгэхгүй байгааг харуулж байна.

Иймд ТАХ-нд шаардагдах санхүүжилтийг 2024 онд бүрэн шийдэх тухай албан шаардлагыг ЗГ-т хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ТАХ-г яаралтай дуусгаагүйгээс Нийслэл өвлийн улиралд хөлдөх эрсдэлд ойрхон байна. !!!

Уг ТАХ хэрэгжсэнээр 11эд магистраль одоо байгаа 2Ф800мм-ийн голчтой шугамыг 2Ф1000мм болгон өргөтгөх шинэчилснээр G=800-1000 тн/ц-аар буюу Q=65-80 Гкал/ц-аар сүлжээний нэвтрүүлэх чадвар нэмэгдэнэ. ДЦС-4 ТӨХК-ийн ф1200 (11а) магистралын сүлжээнээс хангагддаг 1и,е,ж, 8а,б,в,г 7б,в,г,д,и,к, 5б,д,ж, 2а,б,в,г магистралаар дамжуулан хангагддаг хэрэглэгчдийн дулаан хангамж сайжирна. Мөн төгсгөлийн хэрэглэгч болох Баянхошуу дэд төв, 3, 4 дүгээр хороолол, XII хороолол Сансар Мамба дацан зэрэг өндөрлөг цэцэг байрлах хэрэглэгчдийн даралтын зөрүү 5-10 м.у.б-ээр нэмэгдэх чухал ач холбогдолтой юм.

Тухайн шугамын өргөтгөл хийгдсэнээр эх үүсвэр, дамжуулах шугам сүлжээ хооронд ачаалал шилжүүлэн хүлээгдэж буй өсөн нэмэгдэх хэрэглээг ханах техникийн боломж бүрдэх юм. Ингэснээр Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй Орон сууц

¹⁵ Улаанбаатар хотын өргөжин тэлэхэд чухал нөлөө бүхий дэд бүтцийн ажил бөгөөд 40 жил болсон зайлшгүй сольж өргөтгөх шаардлага ТАХ.

хөтөлбөр, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрүүд хэрэгжихэд томоохон түлхэц болно.

2.11. ЭХС-ын багцын "Дулааны цахилгаан станцын өргөтгөл /Дорнод, Хэрлэн сум/" ТАХ нь Монгол улсын ЗГ болон БНХАУ-ын хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа бөгөөд нийт 79.48 сая ам.долларын төсөвт өртөгтэй. Үүнээс Монгол Улсын ЗГ 19.48 сая, БНХАУ-ын Хөгжлийн банк 60.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр тохиролцсон байна.



2.12. Уг ТАХ-ний гүйцэтгэгчээр "ТВЕА" ХХК шалгаран ажиллаж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 42.3 хувьтай ч санхүүжилтийн 22 хувийг олгосон байна.

Ажлын гүйцэтгэл сайн байгаа ч Монгол талын хөрөнгө оруулалт хугацаандаа хийгдэхгүй байгаагаас БНХАУ-ын Хөгжлийн банк гэрээний дагуу 2023 оны 10 сард санхүүжилтээ зогсоох нөхцөл үүссэн байна. ТАХ-ний гэрээний хугацаа 2023.06.30-нд дуусах хэдий ч Монголын талын хөрөнгө оруулалт бүрэн шийдэгдээгүй байна. Мөн Монгол талаас зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх нэгжийг томилгоогүй байна.

ЭХС 2022, 2023 оны төсвийн төсөлд уг ТАХ-ний үлдэгдэл санхүүжилтийг тусган Сангийн яаманд хүргүүлсэн ч ЗГ-аас УИХ-д өргөн барьсан төсөлд тухайн жилд санхүүжүүлэх дүн нь буурсан байна. Улмаар буурсан дүнгээр санхүүжүүлэх дүн нь батлагдсан байна. 2022 оны тухайд төсвийн тодотголоор санхүүжүүлэх дүнг дахин бууруулсан байна.

Тухайн жилд санхүүжүүлэх дүн /тэрбум төгрөг/

Он	ТЕЗ-ын санал	ЗГ-аас өргөн барьсан санал	УИХ баталсан дүн	Тодотголын дүн
2022	35.0	20.0	20.0	10.0
2023	59.9	22.7	22.7	-

2.13. Гүйцэтгэгч тал Монголын тал хөрөнгө оруулалтаа бүрэн шийдвэл 2023 оны эцэст ТАХ-г дуусгах боломжтойг илэрхийлсэн байна. Уг ТАХ-г 2023 оны эцэст бүрэн дуусна гэж тооцоход л гэрээнд заасан хугацаанд (2023.06.30) дуусаагүйгээс 59.28 тэрбум төгрөгийн орлого олох боломжийг алдах тооцоолол гарсан байна.

Иймд ТАХ-нд шаардагдах санхүүжилтийг 2023 онд бүрэн шийдэх тухай албан шаардлагыг ЗГ-т хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Уг ТАХ ашиглалтад орсноор:

ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГ- Зүүн бүс нутгийн хөгжилд уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл тэргүүлэх ач холбогдолтой бөгөөд үүнийг дагаад эрчим хүчний хэрэглээ хурдацтайгаар өсөж 2024 онд нийт хэрэглээ 72 МВт, 2025 онд 92 МВт болж нэмэгдэхээр байна.

Төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын Зүүн бүсийн өсөн нэмэгдэж буй цахилгаан эрчим хүчний хэрэглээг бүрэн хангаж үр дүнд нь уул уурхай, газрын тосны үйлдвэрлэл болон экспортын орлогыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

НИЙГМИЙН ҮР АШИГ- Зүүн бүсэд хэрэгжиж байгаа болон хэрэгжихээр төлөвлөсөн бүтээн байгуулалтуудын эрчим хүчний хэрэгцээг дотоодын эх үүсвэрээр хангаж, байгаль орчинд ээлтэй шинэ технологи нэвтрүүлэх бөгөөд үндэсний боловсон хүчний чадавхыг нэмэгдүүлж, шинээр ажлын байр бий болгоно. Мөн төслийн үр дүнд дулааны

үйлдвэрлэлийн хүчин чадал 2 дахин нэмэгдэж Чойбалсан хотын дулаан хангамж найдваржина. Уг төсөл баригдаж ашиглалтад орсноор авсан зээлийг богино хугацаанд эргүүлэн төлөх боломж бүрдэнэ.

ТӨСЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ- Чойбалсангийн дулааны цахилгаан станцыг өргөтгөх төсөл хэрэгжсэнээр Дорнод, Сүхбаатар аймгийн 36 сум, багийн 25139 айл өрх, 3133 аж ахуйн нэгж, албан байгууллага, уул уурхайн 16 ордын баяжуулах, олборлох үйлдвэрүүдийг тасралтгүй, найдвартай эрчим хүчээр хангана.

Үр дүнтэй хэрэгжсэн төсөл, арга хэмжээ

2.14. БХБС-ын багцын "Төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/" ТАХ нь 2018 оноос эхэлсэн бөгөөд анх 35.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй байсан ч 28.0 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлсэн байна. Уг төслийн хүрээнд:

- Төв цэвэрлэх байгууламжийн дэргэд хуримтлагдсан нийт 27 га талбай бүхий 826 000м3 лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлсэн, (бордоо болгосон)
- Өдөр тутам гардаг шингэн лагийг үнэргүйжүүлж, хоногт 2500 м3 хүч чадалтай лаг усгүйжүүлэх байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулсан байна. Уг байгууламжийг барьснаар түүхий лагийг 3-5 жилийн хугацаанд байгалийн аргаар ил задгай хатааж хуримтлуулдаг байсныг едөрт нь хатаадаг болсон,

Төсөл хэрэгжсэнээр лагын үнэрийн тархалт 4-6 дахин буурсан үзүүлэлт гарсан байна. Тархалтын зураглалыг харуулбал:



Төсөл амжилттай хэрэгжсэн ч цаашид дараах асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна. Үүнд:

- Арьс шир боловсруулах үйлдвэрүүд болон хяналтгүйгээр химийн бодис хэрэглэж байгаа бусад үйлдвэр аж ахуй нэгжүүдийн хариуцлагагүй байдлаас болж одоогоор нийтийн бохир ус, лагаас химийн бохирдол (хром, хар тугалга, мөнгөн ус, хүнцэл зэрэг) илэрч, зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэд дахин хэтэрсэн байна. Үүнээс шалтгаалан төслөөр бэлтгэгдсэн бордоо, хар шороон хөрсийг хэрэглэх боломжгүй болсон байна. Иймд химийн бодис хэрэглэж байгаа

Үйлдвэрүүдэд цэвэрлэх байгууламжтай болгох тухай ЗГ-ын 2018 оны 73 дугаар тогтоолыг мөрдүүлэх,

- Цэвэрлэх байгууламжийн урд ДЦС-4-ийн үнсэн сан болон цэвэрлэсэн лагийн талбайд хог хаягдлыг зөвшөөрөлгүй дахин хаяж, ойр орчныг бохирдуулж, хорт утаа ялгарч байна.¹⁶ Үүнд БОАЖЯ, ЭХЯ, ХХААХҮЯ, БХБЯ хамтарч асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгарсан байна.

Зураг 1: Төв цэвэрлэх байгууламжийн орчимд болон талбайд хаясан хог хаягдал



ДЦС 4-ийн үнс

Лагийн талбайд хаясан хог хаягдал

Иймд химийн бодис хэрэглэж байгаа үйлдвэрүүдийг цэвэрлэх байгууламжтай болгох, лагийн талбайд хог хаяж, ДЦС 4-ийн үнсийг ил задгай хаяж байгаа асуудлуудыг шийдвэрлэх тухай албан шаардлагыг ЗГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.15. СаС-ын багцын Гаалийн шинэчлэлийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гаалийн төв болон салбар лабораториудад АНУ, Герман, Англи, Япон, Швейцари, Итали, Австри, БНХАУ зэрэг орнуудад үйлдвэрлэгдсэн, олон улсад танигдсан Agilent, Thermo scientific, Tanaka, Koehler, Anton Paar, SKIC, Mesdan, Leco, Borgwaldt, Bruker зэрэг брэндийн эрдэс түүхий эд, нүүрс, газрын тосны бүтээгдэхүүн, химийн болон мансууруулах, сэтгэгдэл нөлөөт бодис, согтууруулах ундаа, тамхи, тамхины бүтээгдэхүүн, ноос ноолуур, малын гаралтай ширхэгт материал, эрүүл ахуй, хорио цээр (2022.01.01-ээс хилийн мэргэжлийн хяналтын байгууллага гаалийн байгууллагатай нэгдсэн)-ийн шинжилгээний чиглэлээр орчин үеийн өндөр бүтээмжит, автомат, дэвшилтэт технологид суурилсан тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдсэн байна. Үр дүнг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 3: ГТЛ-ийн 2022 он болон 2021 онтой харьцуулсан байдал



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

¹⁶ Тулгарч байгаа асуудлын талаарх мэдээллийг БХБЯ-аас ирүүлсэн баримтад үндэслэн бэлтгэсэн болно.

Дээрх үзүүлэлтээс харахад 2022 оны байдлаар ГТЛ-д хийгдсэн магадлан шинжилгээний тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дээжийн тоо 0,88%, дүгнэлтийн тоо 1,76%-аар буурсан нь салбар лабораториуд дээр нүүрс, нефтийн болон эрдсийн шинжилгээ хийдэг болсонтой холбоотой байна.

2.16. ГТЛ дээр эрдэс, хүдэр баяжмал, нүүрсний шинжилгээ хийдэг болсноор улсын төсөвт оруулах орлого өмнөх оноос 0.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хийж буй хяналт сул байна.

Аудитын явцад зарим барилга байгууламжийн ажлын явц, гүйцэтгэлтэй танилцахад дараах асуудал илэрлээ. Тухайлбал:

2.17. ЭМС-ын багцын Халдварт өвчин судлалын үндэсний төвийн III шатлалын лабораторийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ ТАНХ-г "Энигма констракшн"ХХК 19.7 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан ба барилга угсралтын ажилд дараах зөрчлүүд гарсан байна. Тухайлбал:

Био аюулаүй ажиллагааны дүрэмд "Лабораторийн хаалга битүү, завсар зайгүй өөрөө хаагддаг нугастай, хаалганд босоо хүний өндрийн хэмжээнд доторх зүйлийг бүрэн харахуйц цонхтой байна" гэж тусгаасан ч лабораторийн хаалганы битүүмжлэл муу, хаасан үед завсар зай үлдэж байна.		
Био аюулаүй ажиллагааны дүрэмд "Шал халтирдаггүй, шалны гадаргууг өглөөр, цэвэрлэхэд хялбар, шингэн нэвтрүүлдэггүй, лабораторид тогтмол хэрэглэдэг химийн болон халдваргүйжүүлэх бодист тэсвэртэй материалаар хийсэн байхаар" тусгаасан ч лабораторийн шалны будаа, хулдаас нь биоаюулаүй байдлын 3-р зэрэглэлийн ашиглалтын шаардлага хангаагүй байна.		
Лифт нь байнга зөдрэл гэмтэл гарч зогсдог, хэвийн ажиллагаагүй болсон, лифтийг ашиглагчид хүлээлгээн өгөөгүйгээс засвар үйлчилгээ авах боломжгүй нөхцөл үүссэн.		
Лабораторийн өрөөнүүдийн агааржуулалтын систем, түүний шугам хоолойн угсралтын ажил төхник технологийн шаардлага хангаагүй.		
Гадна бохирын шугамын түвшин зөрсөн, барилгын зоорийн давхарын таазаар гарсан хэсэг нь ил суурилуулагдаж дулаалга хийгдээгүйгээс бохир хөлдөж зоорийн давхар бохирт автсан. Гадна бохирын худгийг хөлдөлтийн гүнд суулгаагүйгээс хөлдсөн.		

Хөрсний ус цуглуулах дренажын систем нь цуглуулсан усыг соруулж барилгааг гадагшлуулахгүй байснаар трал дүүрэн зоорийн давхар усанд автсан, зоорийн давхрын шал, шалны хөвөө, ханаар хөрсний ус нэвчсэн.

Холбооны өрөө рүү /камерын хяналтын өрөө/ бохир ус алдсаны улмаас одоогоор ашиглагдахгүй байна. Давхруудад тавигдсан галын дохиолол, камер, зарлан мэдээлэх системүүд нь ажилладаггүй.



2.18. Барилгын ажлын гүйцэтгэлд гарсан зөрчлүүдийн улмаас барилга байгууламжийг Халдварт өвчин судлалын III шатлалын лабораторийн зориулалтаар ашиглах боломжгүй байна.

Эдгээр зөрчлийн талаар Халдварт өвчин судлалын үндэсний төв 2022 онд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүсэлт хүргүүлсний улмаас Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас холбогдох улсын байцаагчид ажиллан гүйцэтгэгч компанид "Дутагдал арилгуулах тухай" 2022.07.07-ны өдрийн 01-07-104/136 дугаартай албан шаардлага хүргүүлсэн байна. Гэсэн хэдий ч тус компани зөрчлийг арилгаагүй байна.

2.19. Уг ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ, зохиогчийн хяналтыг "Хатанбаатар" ХХК хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан ажилласан ч хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Мөн барилгыг байнгын ашиглалтад оруулах улсын комисс өгсөн үүрэг, даалгавраа биелээгүй байхад улсын комиссын дүгнэлтүүдийг үндэслэлгүйгээр баталгаажуулж, ашиглалтад оруулсан байна.

Иймд барилга байгууламжийг хүлээн авч ашиглалтад оруулсан улсын комиссын бүрэлдэхүүнийг хуулийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

ХААХҮС-ын багц:

2.20. "Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламж /Ховд, Жаргалант сум" ТАХ-ний гүйцэтгэгчээр "Саруул цамхаг" ХХК-ийг 2018 онд түлхүүр гардуулах нөхцлөөр сонгон шалгаруулж 4.8 тэрбум төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна. Уг ТАХ-ний төсөв нь 2019 онд магадлалаар баталгаажихдаа 6.9 тэрбум төгрөгөөр хянагдсан байна. Үүнтэй холбоотойгоор ажил гүйцэтгэх гэрээг шинэчлэх асуудал шийдвэрлэгдээгүйгээс ТАХ дуусаагүй байна. ТАХ удааширнаас цэвэрлэх байгууламжид суурилуулах зарим тоног төхөөрөмж ашиглах боломжгүй болсон байна.



Эдгээр тоног төхөөрөмжийг 2014 онд хүлээн авсан бөгөөд хадгалалтын горим алдагдсанаас ашиглалтын шаардлага хангахгүй болсон байна. Шаардлага хангахгүй тоног төхөөрөмжийн

засвар үйлчилгээнд нийт 2.92 сая юань буюу 1.4 тэрбум төгрөгийн зардлын тооцоо гарсан байна.

2.21. Дээрх ТАХ бүрэн хэрэгжээгүй байхад тус сайдын багцад 2022 онд шинээр хэрэгжүүлэх "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/ ТАХ-ний хүрээнд дахин "Арьс шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн зураг төсөв боловсруулах, барих" ажлыг 2.0 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна.

Энэ нь захиалагч тал тухайн орон нутагт шаардлагатай ТАХ-г оновчтой тодорхойлохгүй, хөрөнгө оруулалтын төлөвлөлт хангалтгүй байгааг харуулж байна.

БШУС-ын багц:

2.22. БШУС-ын багцад 2022 онд хэрэгжиж байгаа дараах ТАХ нь холбогдох хууль, журам, норм, стандартыг мөрдөж ажиллаагүй байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6¹⁷, 14.1.1¹⁸, 14.1.2¹⁹, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 10 сарын 19-ний өдрийн 211 дүгээр тушаалын 5.2.9²⁰-д заасныг тус тус зөрчсөн байна.

- Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Хөвсгөл, Их-Уул сум/ Төсөвт өртөг-4,450.9 сая төгрөг Гүйцэтгэгч "Уул-өвгөд" ХХК-ийн барилга угсралтын явцад дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Цонх угсрахдаа барилгын талбайд үйлдвэрлэсэн, цонхны тавцан ажлын зурагт чулуун хагтан гэснийг өөрчлөн хуванцар /PVC/ материалтай тавцан суурилуулсан,
- Барилгын спорт заалны шалыг зураг төсвийн дагуу бус хулдаас болгон өөрчилж материал татан авсан,
- ХБИ-нд зориулсан налуу, орц гарцыг төлөвлөөгүй, барилга байгууламжийн угсралтын ажил дууссан ч дулааны эх үүсвэрийн ачаалал нь хүрэхгүйн улмаас барилгыг байнгын ашиглалтад хүлээн авах боломжгүй болж, заслын нойтон ажлууд чанаргүй болох нөхцөл үүссэн байна.

- Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 44 дүгээр сургууль/2018-2022/, төсөвт өртөг-3.5 тэрбум төгрөг/ Гүйцэтгэгч "Урагшлах" ХХК. дээврээс ус нэвтэрсэн, коридорын шалны хийцлэлийг өөрчилж, плитан шал хийсэн,
- Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 34 дүгээр цэцэрлэг/ Төсөвт өртөг-2.8 тэрбум төгрөг, гүйцэтгэгч Бизнес фокус ХХК. Комисс 2022 оны 12 дугаар сард ажилласан боловч 2023 оны 03 дугаар сард ашиглаж эхлээгүй, комиссын үүрэг даалгавар биелээгүй, гадна гэрэлтүүлэг, тоглоомын талбайн ажил дутуу,
- Цэцэрлэгийн барилга худалдан авах, 300 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ төсөвт өртөг-3.5 тэрбум төгрөг, гүйцэтгэгч "Жаргалтай хотхон" цэцэрлэг боловсрол, сургалтын байгууллага. Зоорийн давхрын агааржуулалт ажиллахгүй учир соёлын

¹⁷ 11.1.6 барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөгдөн баригдсан байх
¹⁸ 14.1.1. зураг төслийн дагуу баригдсан байх;
¹⁹ 14.1.2. барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангасан байх;
²⁰ 5.2.9.1. Спорт заалны төлөвлөлтийг спортын барилга байгууламжийн норм, дүрмийн шаардлагад нийцүүлнэ. Спорт заал нь зориулалтын модон шалтай байна"

танхим нь үйл ажиллагаа явуулах боломжгүй байгаа зэрэг зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлагыг Боловсролын ерөнхий газарт хүргүүлэв.

ЗТХС-ын багц:

2.23. "Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Шарын гол сум/" ТАХ нь 47.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 2019 оноос хэрэгжиж эхэлсэн байна. Уг ТАХ-г дараах байдлаар багцалсан байна.

Хүснэгт 18: ТАХ-г багцад хуваасан мэдээлэл /тэрбум төгрөг/

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	дуусах	Төсөвт өртөг	Тухайн жилийн төсөв
XV.1.1.18	Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Шарын гол сум/	2019	2022	47.9	18.7
XV.1.1.18.1	Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Шарын гол сум/ Багц- 1	2019	2022	47.9	9.3
XV.1.1.18.2	Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Шарын гол сум/ Багц-2				5.5
XV.1.1.18.3	Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Шарын гол сум/ Багц-3				3.9

Эх сурвалж: ЗТХС-ын тушаал

Дархан-Уул аймгийн ЗДТГ нь "Мөнхийн тод зам" ХХК-тай зураг, төсөл боловсруулах нэмэлт гэрээ байгуулан авто замын чиглэлийн нэрийг сольж, "Зам Тээврийн Хөгжлийн Төв"-өөр магадлан хийлгэн баталгаажуулсан байна.

2.24. "Дэлүүн болдог нисэх буудлын барилга /Хэнтий, Дадал сум/" ТАХ-г 2020 онд ЗТХЯ гүйцэтгэгч "Биг Монголиа билдинг" ХХК-тай түлхүүр гардуулах нөхцөлтэй, 4.8 тэрбум төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна.

Гэвч захиалагчийн хүсэлтээр зураг, төсөвт өөрчлөлт орж төсөвт өртөг 3.6 тэрбум төгрөгөөр төсвийн тооцооллыг нэмэгдүүлсэн байна. Барилгын ажлын нэгдсэн төсөвт Барилгын хөгжлийн төв 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдөр магадлал хийж барилгын нийт төсвийг 8.4 тэрбум төгрөгөөр баталгаажуулсан байна.

Нэмэгдсэн дүн буюу 3.6 тэрбум төгрөгийн ажилд 4 удаа тендер зарласан ч амжилтгүй болсон байна. Захиалагч ТБОНХБАҮХУТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.4.1-т заасны дагуу шалтгааныг судалж шаардлагатай арга хэмжээг авч ажиллаагүй байна. Уг заалтын дагуу шаардлагатай арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж хүргүүлээ.

Уг ажлыг 2021 онд Иргэний нисэхийн ерөнхий газарт эрх шилжүүлэн хэрэгжүүлж байна. Тус газар нь захиалагчийн хяналтыг БХТ-өөр, зохиогчийн хяналтыг "Алтайн газрын хүч" ХХК-иар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.

2.25. Барилга угсралтын ажилд дараах асуудлууд үүссэн байна.

Төлөвлөсөн зураг



Бодит гүйцэтгэл



Гүйцэтгэгч "Биг монголиа билдинг" ХХК цутгамал төмөр бетон каркасны угсралтын бетонд БХТ-ын лабораторийн хийсэн сорьцын шинжилгээний дүгнэлтэд "Е-11 тэнхлэг дэх 2-р давхрын багана, Д-6 тэнхлэг дэх 3-р давхрын багана, Е6-Е7 тэнхлэг дэх 3-р давхрын дам нуруу, Д7-Д7 тэнхлэг дэх 1-р давхрын дам нуруу, Е-5 тэнхлэг дэх 2-р давхрын баганын бетоны марк нь бетоны бат бэхийн харгалзах утгад хүрээгүй" гэж туссан ч БХТ, ИНЕГ арга хэмжээ аваагүй.

Дотор цахилгаан, холбоо дохиоллын кабель сүвлэх хамгаалалтын хоолойг зураг төслийн дагуу хучилтад хийж цутгалт аваагүй байдалтай байна. Энэ нь цутгамал хучилтыг арматурыг тастаж бетоныг цоолж гүйцэтгэх нөхцөл үүссэн бөгөөд цутгамал хучилт зураг төслийн утгад хүрэхгүй болсон байгаа нь төмөр бетон арагт бүтээц нь газар хөдлөлийн норм дүрэм хангахгүй болсон.

Барилгын зураг төсөл захиалагчийн хүсэлтээр өөрчлөгдсөнтэй холбоотой гадна хийцийн материалыг БНХАУ-д захиалан хийлгэсэн ч цар тахлын хөл хорионы нөхцөл байдлаас шалтгаалан татан авалтын хугацаа хойшлогдсон байна.

Одоогийн байдлаар анх байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэх ажлын 65 хувийг гүйцэтгэсэн байна.

Иймд гарсан зөрчил дутагдлыг зураг төслийн зохиогч, захиалагчтай зөвшилцөн тухайн хийцүүдийг БД 22-106-18-ний дагуу хүчитгэн гүйцэтгүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

ХЗДХС-ын багц:

2.25. Тус сайдын багцад хэрэгжиж байгаа зарим ТАХ-ний материалыг сольж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

- Гадаадын иргэн, харьяатын газрын баруун бүс дэх газрын үйлчилгээний цогцолборын барилга /Хөвд, Жаргалант сум/ ТАХ-ний БУА гүйцэтгэх ГИХГ/202201010 дугаартай гэрээг 2022.03.30-ны өдөр АСИАНСИТИ ХХК-тай 2.4 тэрбум төгрөгийн дүнтэй байгуулсан ч орон нутагт газрыг өөрчилснөөс БУА оройтож, ажлын гүйцэтгэл 2022 онд 70% байна. Гэвч хил гааль хаалттай материалын олдоц ховор гэсэн үндэслэлээр гүйцэтгэгч компани зохиогчийн зөвшөөрлөөр батлагдсан зураг төсөл, төсөв дэх дээврийн ажлын мембран материалыг хар цаас болгон өөрчилсөн.
- Цагдаагийн хэлтсийн барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум/ ТАХ-ний БУА-ын гүйцэтгэх ЦЕГ/202112001 дугаартай гэрээг Их-Модун ХХК-тай 2021.05.13 өдөр 2.1 тэрбум төгрөгийн дүнтэйгээр байгуулжээ. Гэвч БУА-ын явцад барилгын 431.57м.кв дотор шалны өнгөлгөөний боржин чулуун хавтан дээсэж хийхээр байсныг плитагаар сольж хийсэн байна.

Энэ хэдийгээр захиалагч болон зохиогчтой зөвшилцөн Барилгын тухай хуулийн 38.1.6 Барилга байгууламжийн зураг төсөлд өөрчлөлт оруулах захиалагчийн санал барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт тавих чанар аюулгүй байдлын

танхим нь үйл ажиллагаа явуулах боломжгүй байгаа зэрэг зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлагыг Боловсролын ерөнхий газарт хүргүүлэв.

ЗТХС-ын багц:

2.23. "Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Шарын гол сум/" ТАХ нь 47.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 2019 оноос хэрэгжиж эхэлсэн байна. Уг ТАХ-г дараах байдлаар багцалсан байна.

Хүснэгт 18: ТАХ-г багцад хуваасан мэдээлэл /тэрбум төгрөг/

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	дуусах	Төсөвт өртөг	Тухайн жилийн төсөв
XV.1.1.18	Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Шарын гол сум/	2019	2022	47.9	18.7
XV.1.1.18.1	Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Шарын гол сум/ Багц- 1	2019	2022	47.9	9.3
XV.1.1.18.2	Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Шарын гол сум/ Багц-2				5.5
XV.1.1.18.3	Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Шарын гол сум/ Багц-3				3.9

Эх сурвалж: ЗТХС-ын тушаал

Дархан-Уул аймгийн ЗДТГ нь "Мөнхийн тод зам" ХХК-тай зураг, төсөл боловсруулах нэмэлт гэрээ байгуулан авто замын чиглэлийн нэрийг сольж, "Зам Тээврийн Хөгжлийн Төв"-өөр магадлан хийлгэн баталгаажуулсан байна.

2.24. "Дэлүүн болдог нисэх буудлын барилга /Хэнтий, Дадал сум/" ТАХ-г 2020 онд ЗТХЯ гүйцэтгэгч "Биг Монголиа билдинг" ХХК-тай түлхүүр гардуулах нөхцөлтэй, 4.8 тэрбум төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна.


Гэвч захиалагчийн хүсэлтээр зураг, төсөвт өөрчлөлт орж төсөвт өртөг 3.6 тэрбум төгрөгөөр төсвийн тооцооллыг нэмэгдүүлсэн байна. Барилгын ажлын нэгдсэн төсөвт Барилгын хөгжлийн төв 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдөр магадлал хийж барилгын нийт төсвийг 8.4 тэрбум төгрөгөөр баталгаажуулсан байна.

Нэмэгдсэн дүн буюу 3.6 тэрбум төгрөгийн ажилд 4 удаа тендер зарласан ч амжилтгүй болсон байна. Захиалагч ТБОНХБАҮХУТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.4.1-т заасны дагуу шалтгааныг судалж шаардлагатай арга хэмжээг авч ажиллаагүй байна. Уг заалтын дагуу шаардлагатай арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж хүргүүлээ.

Уг ажлыг 2021 онд Иргэний нисэхийн ерөнхий газарт эрх шилжүүлэн хэрэгжүүлж байна. Тус газар нь захиалагчийн хяналтыг БХТ-өөр, зохиогчийн хяналтыг "Алтайн газрын хүч" ХХК-иар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.

2.25. Барилга угсралтын ажилд дараах асуудлууд үүссэн байна.

Төлөвлөсөн зураг



Бодит гүйцэтгэл



Гүйцэтгэгч "Биг монголиа билдинг" ХХК цутгамал төмөр бетон каркасны угсралтын бетонд БХТ-ын лабораторийн хийсэн сорьцын шинжилгээний дүгнэлтэд "Е-11 тэнхлэг дэх 2-р давхрын багана, Д-6 тэнхлэг дэх 3-р давхрын багана, Е6-Е7 тэнхлэг дэх 3-р давхрын дам нуруу, Д7-Д7 тэнхлэг дэх 1-р давхрын дам нуруу, Е-5 тэнхлэг дэх 2-р давхрын баганын бетоны марк нь бетоны бат бэхийн харгалзах утгад хүрээгүй" гэж туссан ч БХТ, ИНЕГ арга хэмжээ аваагүй,

Дотор цахилгаан, холбоо дохиоллын кабель сүвлэх хамгаалалтын хоолойг зураг төслийн дагуу хучилтад хийж цутгалт аваагүй байдалтай байна. Энэ нь цутгамал хучилтыг арматурыг тастаж бетоныг цоолж гүйцэтгэх нөхцөл үүссэн бөгөөд цутгамал хучилт зураг төслийн утгад хүрэхгүй болсон байгаа нь төмөр бетон арагт бүтээц нь газар хөдлөлийн норм дүрэм хангахгүй болсон.

Барилгын зураг төсөл захиалагчийн хүсэлтээр өөрчлөгдсөнтэй холбоотой гадна хийцийн материалыг БНХАУ-д захиалан хийлгэсэн ч цар тахлын хөл хорионы нөхцөл байдлаас шалтгаалан татан авалтын хугацаа хойшлогдсон байна.

Одоогийн байдлаар анх байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэх ажлын 65 хувийг гүйцэтгэсэн байна.

Иймд гарсан зөрчил дутагдлыг зураг төслийн зохиогч, захиалагчтай зөвшилцөн тухайн хийцүүдийг БД 22-106-18-ний дагуу хүчтгэн гүйцэтгүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

ХЗДХС-ын багц:

2.25. Тус сайдын багцад хэрэгжиж байгаа зарим ТАХ-ний материалыг сольж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

- Гадаадын иргэн, харьяатын газрын баруун бүс дэх газрын үйлчилгээний цогцолборын барилга /Ховд, Жаргалант сум/ ТАХ-ний БУА гүйцэтгэх ГИХГ/202201010 дугаартай гэрээг 2022.03.30-ны өдөр АСИАНСИТИ ХХК-тай 2.4 тэрбум төгрөгийн дүнтэй байгуулсан ч орон нутагт газрыг өөрчилснөөс БУА оройтож, ажлын гүйцэтгэл 2022 онд 70% байна. Гэвч хил гааль хаалттай материалын олдоц ховор гэсэн үндэслэлээр гүйцэтгэгч компани зохиогчийн зөвшөөрлөөр батлагдсан зураг төсөл, төсөв дэх дээврийн ажлын мембран материалыг хар цаас болгон өөрчилсөн.
- Цагдаагийн хэлтсийн барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум/ ТАХ-ний БУА-ын гүйцэтгэх ЦЕГ/202112001 дугаартай гэрээг Их-Модун ХХК-тай 2021.05.13 өдөр 2.1 тэрбум төгрөгийн дүнтэйгээр байгуулжээ. Гэвч БУА-ын явцад барилгын 431.57м.кв дотор шалны өнгөлгөөний боржин чулуун хавтан дээсэж хийхээр байсныг плитагаар сольж хийсэн байна.

Энэ хэдийгээр захиалагч болон зохиогчтой зөвшилцөн Барилгын тухай хуулийн 38.1.6 Барилга байгууламжийн зураг төсөлд өөрчлөлт оруулах захиалагчийн санал барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт тавих чанар аюулгүй байдлын

шаардлагад нийцсэн тохиолдолд зөвшөөрч, баталгаажуулах гэж заасны дагуу хийгдсэн ч тухайн барилга байгууламжуудын чанар байдал насжилтад сөргөөр нөлөөлж цаашлаад урсгал болон хөрөнгө оруулалтын зардал өсөх нөхцөлийг үүсгэж байна

2.26. ТАХ-ний гүйцэтгэлд гарч буй зөрчлөөс харахад захиалагч болон зохиогчийн хяналт үр дүн муутай байна.

2.27. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний захиалагчийн хяналтыг Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Зам тээврийн хөгжлийн төв голлон хэрэгжүүлж, зохиогчийн хяналтыг зураг, төсөв боловсруулсан хуулийн этгээд хэрэгжүүлж байна. Хяналт хэрэгжүүлж байгаа газрууд хяналт хийсэн үйл явцаа баримтжуулж тайлангаа төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн ажиллаж байгаа ч барилга байгууламжийн гүйцэтгэлд гарч буй зөрчил жил бүр давтагдан гарсаар байна.

"Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын захиалагчийн хяналт, нормчлолын сангийн зарцуулалтын үйл ажиллагаа нь эрсдэлтэй байгаа тул "ЭРСДЭЛИЙН АУДИТ" хийх шаардлагатай байна.

2.28. Зарим тохиолдолд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн баримтгүйгээр захиалагчийн хяналтын зардлыг авсан зөрчил гарч байна. Тухайлбал:

- БХБС-ын багцын "Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г, д Ø800-ийн гол шугамыг Ø1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөв, барилга угсралтын ажил" ТАХ-ний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээ байгуулаагүй, хяналт хийсэн баримтгүй Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар захиалагчийн хяналтын зардлын 70 хувь буюу 0.3 тэрбум төгрөгийг авсан байна.

2.29. Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэж заасан ч улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд ТЕЗ-дын дотоод аудитын нэгж огт хяналт хэрэгжүүлээгүй, хариуцлагагүй хандсан байна.

Зарим төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.

2.30. Нийт ТАХ-ний тухайн жилийн санхүүжих дүнгийн гүйцэтгэлийг авч үзэхэд 88.8 хувьтай буюу 1,238.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс 93.7 хувь буюу 1,160.5 тэрбум төгрөгийг ажлын бодит гүйцэтгэлээр олгож, 6.3 хувь буюу 77.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Засгийн газрын 2022 оны 495 дугаар тогтоолд үндэслэн ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

ТЕЗ-дын барьцаа хөрөнгийн дансанд жил бүр ЗГ-ын тогтоолоор ТАХ-ний санхүүжүүлээгүй үлдэгдлийг байршуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3²¹, 43.1.5²²-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй" гэж заасныг зөрчиж байна.

2.31. Хууль зөрчиж гаргасан уг тогтоолоо мөн л зөрчдөг байдал хэвээрээ буюу тогтоолд заасан хугацаанд ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлээгүй байна. Аудитын явцад

²¹ Улсын Их Хурлаас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээгээр болон олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөв.

²² төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан тусламж, хандив.

санхүүжүүлээгүй үлдэгдэлд төлбөрийн акт тогтоох, тухайн зөрчлийг залруулах замаар төсөвт төвлөрүүлв. Тухайлбал:

- Боловсролын ерөнхий газрын барьцаа хөрөнгийн дансанд 32 ТАХ-ний 2021 онд санхүүжүүлэхээр тусгагдсан, олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдэл болох 11.4 тэрбум төгрөг байршиж байсан,
- ЭМЯ-ны барьцаа хөрөнгийн дансанд 4 ТАХ-ний 2019, 2020, 2021 онд санхүүжүүлэхээр тусгагдсан, олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдэл болох 0.5 тэрбум төгрөг байршиж байсан,
- СоЯ-ны барьцаа хөрөнгийн дансанд 3 ТАХ-ний 2020, 2021 онд санхүүжүүлэхээр тусгагдсан, олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдэл болох 0.8 тэрбум төгрөг байршиж байсан,
- ЗТХЯ-ны барьцаа хөрөнгийн дансанд 1 ТАХ-ний 2021 онд санхүүжүүлэхээр тусгагдсан, олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдэл болох 1.4 тэрбум төгрөг байршиж байсан,
- БХБЯ-ны барьцаа хөрөнгийн дансанд 6 ТАХ-ний 2021 онд санхүүжүүлэхээр тусгагдсан, олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдэл болох 2.9 тэрбум төгрөг байршиж байсан, (Үүнээс 5 ТАХ-ний 2.6 тэрбум төгрөгт албан шаардлага өгсөн)
- СаЯ-ны барьцаа хөрөнгийн дансанд 15 ТАХ-ний 2021 онд санхүүжүүлэхээр тусгагдсан, олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдэл болох 10.1 тэрбум төгрөг байршиж байсан, (Уг зөрчилд албан шаардлага өгсөн)
- БТСУХ-ны барьцаа хөрөнгийн дансанд 1 ТАХ-ний 2021 онд санхүүжүүлэхээр тусгагдсан, олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдэл болох 1.3 тэрбум төгрөг байршиж байсан,
- Мөн санхүүгийн тайлангийн аудитын явцад уг зөрчилд төлбөрийн акт тогтоон төсөвт төвлөрүүлсэн байна.

2.32. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд ТАХ-ний бодит гүйцэтгэлд нийт 1,160.5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Тодруулбал төсвөөс улсдаа 1,160.5 тэрбум төгрөгөөр хийсэн хөрөнгө оруулалт нь улсын эдийн засгийн үзүүлэлтүүдэд хэрхэн нөлөө үзүүлж байгаа талаар үнэлгээ дүгнэлт байхгүй байна.

ТАХ-ний бодит гүйцэтгэлийг газар дээр нь тулган баталгаажуулж олгосон санхүүжилтийн баримттай харьцуулахад дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

БХБС-ын багцад:

- "Сумын төвийн шинэчлэл" /Баянхонгор аймаг, Галуут сум/ ТАХ нь Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуульд 5.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй туссан бөгөөд "Алевротовер констракшн" ХХК 2021 онд 4.9 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан байна. Тус компани 4 удаагийн гүйцэтгэлээр нийт 4.8 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан ч гүйцэтгэсэн ажлын бодит гүйцэтгэл нь 3.6 тэрбум төгрөг буюу 1.2 тэрбум төгрөгийн илүү санхүүжилт авсан байна.
Нөгөө талаар уг ажлын магадлалаар баталгаажсан төсөвт өртөг нь 9.9 тэрбум төгрөг бөгөөд зарим ажил зураагүй, зарим зураг нь алдаатай байгаа нь төлөвлөлт хангалтагүй байгааг харуулж байна.
- "Сумын төвийн шинэчлэл" /Баянхонгор аймаг, Эрдэнэцоог сум/ ТАХ нь Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуулинд 5.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй туссан бөгөөд "Бридж Бюлдине" ХХК 2021 онд 4.9 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан байна. Тус компани 3 удаагийн гүйцэтгэлээр нийт 4.3 тэрбум

төгрөгийн санхүүжилт авсан ч гүйцэтгэсэн ажлын бодит гүйцэтгэл нь 1.2 тэрбум төгрөг буюу 3.1 тэрбум төгрөгийн илүү санхүүжилт авсан байна. Бодитоор хийж гүйцэтгэсэн ажлууд (авто зам, бохирын шугам, тохижилтын талбай) нь чанаргүйгээс ашиглах боломжгүй байна.

Нөгөө талаар уг ажлын магадлалаар баталгаажсан төсөвт өртөг нь 5.2 тэрбум төгрөг бөгөөд зарим ажил зураггүй, зарим зураг нь алдаатай байгаа нь төлөвлөлт хангалтгүй байгааг харуулж байна.

- "Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг", төсөвт өртөг нь 5.0 тэрбум төгрөг бүхий ТАХ-г "Монгол дайван" ХХК гүйцэтгэхээр 2013 онд гэрээ байгуулж нийт санхүүжилтийн 90 хувийг авч ажлыг эхлүүлсэн ч 10 жилийн дараа зөвхөн усан хангамжийн шугам сүлжээг ашиглалтад оруулсан байна. Уг ТАХ-ний зураг, төсөл иж бүрэн хийгдээгүй буюу авто замын зураг төсөл байхгүй, магадлалаар баталгаажсан гадна усан хангамж, ариутгах шугамын 2.58 тэрбум төгрөгийн төсөв л байна.

Тус компани нь одоогийн байдлаар санхүүжилтээ бүрэн авсан бөгөөд дараах санхүүжилтийг ажил нь хийгдээгүй байхад авсан байна. Үүнд: Хийн хангамж, иргэдтэй зөвшилцөх, магадлалгүй ажлын зардал болох нийт 1.2 тэрбум төгрөгийг ажлаа хийгээгүй авсан байна.

- "Сумдад хүүхдийн тоглоомын талбай байгуулах төсөл /Булган/ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ төсөл, арга хэмжээ тус бүрд зургийн мөнгийг тооцож нийт 0.02 тэрбум төгрөгийг илүү олгосон нь Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 2.3.2.5-д "барилга байгууламжийн зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт бичиг, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх" заалтыг зөрчсөн байна.
- "Үерийн хамгаалалтын байгууламж" /Хэнтий, Хэрлэн/ ТАХ нь 13.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд "Нью констракшн" ХХК 10.9 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр 2021 онд гэрээ байгуулсан байна. Тус компани 5 удаагийн гүйцэтгэлээр нийт 5.6 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан ч гүйцэтгэсэн ажлын бодит гүйцэтгэл нь 3.2 тэрбум төгрөг буюу 2.4 тэрбум төгрөгийн илүү санхүүжилт авсан байна.

ЗТХС-ын багцад:

- "Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөл, 5.5км хатуу хучилттай авто, унадаг дуугийн замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /дорнод, хэрлэн сум, 1, 4, 6, 7, 8, 9, 10 дугаар баг/ боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ"-а "Ар Си Эс Си" ХХК-ний гүйцэтгэх захирал Д.Нямдаваа, "Хөгжлийн Хөтөч Дэд Бүтэц" Төслийн зохицуулагч Х.Болор-Эрдэнэ нар 2018 оны 07 сарын 06-ны өдөр батлан зөвлөх үйлчилгээний ажлын №ТӨБЗГ-2018/VIII.4.1.1 тоот гэрээг 0.3 тэрбум төгрөгийн дүнтэйгээр байгуулсан байна.

Нийт барилгын материалын тээврийн зардлын тооцоог 0.5 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэсэн бөгөөд шинжээч нь төсвийн алдаа дутагдал, тээврийн зайг шинэчлэн хийж гүйцэтгэвэл 0.4 тэрбум төгрөг болох бөгөөд 0.1 тэрбум төгрөгөөр илүү тооцсон байна.

Эдгээр нь ЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.1.12-г зөрчсөн тул илүү авсан санхүүжилтээр ажлыг гүйцэтгүүлэх тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Зарим төсөл, арга хэмжээний ашиглалт хангалтгүй байна.

2.33. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд туссан нийт 1369 ТАХ-ээс хэрэгжиж дууссан нийт 495 ТАХ-нд улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан байна. Ашиглалтад хүлээн авсан зарим ТАХ-ний ашиглалт хангалтгүй байна. Тухайлбал:

БХБС-ын багцад:

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд БХБС-ын багцад туссан нийт 65.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/ ТАХ-ний гүйцэтгэлийг харуулбал

Хүснэгт 19: Дараа онуудад хэрэгжүүлэх ТАХ-ний зураг, төсвийн гүйцэтгэл ашиглалт /тэрбум төгрөг/

Нийт ТАХ-ний тоо		Хэрэгжих дууссан ТАХ-ний			Монгол Улсын 2021-2023 оны төсвийн тухай хуульд тусгаагүй ТАХ-ний		
Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжүүлсэн дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжүүлсэн дүн
264	65.9	146	31.5	30.7	88	16.1	15.7

Эх сурвалж: Монгол улсын 2021-2023 оны төсвийн тухай хууль, БХБЯ-аас авсан гүйцэтгэлийн баримт

Дээрх үзүүлэлтээс харахад хэрэгжиж дууссан нийт 146 зураг, төсвөөс 88 буюу 60.2 хувь нь ашиглагдаагүй, өөрөөр хэлбэл барилга байгууламж нь Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуульд тусгагдаагүй байна. Гэтэл магадлалаар баталгаажсан зураг, төсөвгүй нийт 406 ТАХ 2022 онд шинээр хэрэгжихээр хуульд туссан байна.

2.34. Энэ нь улсын төсвөөс санхүүжүүлсэн нийт 15.7 тэрбум төгрөг үр өгөөжөө өгөөгүй, дараа жилүүдэд ТАХ нь хуульд тусгахгүй тохиолдолд нэмэлт үргүй зардал гарах нөхцөлийг бий болгож байна. Нөгөө талаар нэн тэргүүнд шаардлагатай ТАХ-ний зураг, төсвийг хийгээгүй буюу улсын хэмжээнд шаардлагатай ТАХ-г зөв эрэмбэлж чадахгүй байгааг харуулж байна.

БШУС-ын багцад:

2.35. Боловсролын салбарт тоног төхөөрөмж худалдан авах ТАХ-ний нийт төсөвт өртгийн 13%-60% санхүүжүүлэхээр төлөвлөсөн ба үлдэгдэл санхүүжилтийг 2023 оны төсвийн тухай хуульд тусгаагүй, ТАХ-г бүрэн хэрэгжүүлэхэд 2.4 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна.

- Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян Өндөр, Жаргалант сум/
- Сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21 дүгээр хороо/
- Сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж /Өмнөговь/
- Сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 6, 8, 13, 14, 15, 16, 18, 25, 26 дугаар хороо/

2.36. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар боловсролын салбарт худалдан авсан 117 нэр төрлийн 21,180 ширхэг 5.1 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаагүй, гэрээний дагуу бэлтгэн нийлүүлсэн аж ахуй нэгжийн агуулахад 1-3 жил хадгалж

байгаа нь худалдан авсан тоног төхөөрөмжийн эдэлгээ, чанар байдалд муугаар нөлөөлөх, хадгалалтын горим алдагдах, тоног төхөөрөмжийг зориулалт бусаар ашиглах, үрэгдэх, зорилтот эцсийн хэрэглэгчдэд хүргээгүйгээс төсөл арга хэмжээ үр дүнгүй болох, үр ашгийг бууруулах зэрэг эрсдэл үүссэн тул Боловсролын ерөнхий газарт албан шаардлага хүргүүлэв.

БОАЖС-ын багцад:

2.37. "Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхгийн байр" ТАХ нь "Тус яамны харьяа Цаг уур, орчны шинжилгээний газрын антenuуд эргэн тойрны өндөр барилгуудад халхлагдан, ажиллахад хүндрэл учирсан, супер компьютер байршуулах тусгай зориулалтын өрөө шаардлагатай" зэрэг хэрэгцээ, шаардлагын дагуу батлагдсан байна.

Гэсэн хэдий ч тус барилгын ажлын даалгавар, зураг төсөвт дээрх шаардлагууд тусаагүй, улмаар энэ зураг төсвийн дагуу барилга баригдсан байна. Одоогийн байдлаар тус барилгад супер компьютер, антен зэргийг байршуулаагүй, Цаг уур, орчны шинжилгээний газрын албаны байрын зориулалтаар ашиглаж байна.

ХХААХҮС-ын багцад:

2.38. Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд аймгуудад нийлүүлсэн хүлэмж, газар тариалангийн тоног төхөөрөмж, гар урлалын тоног төхөөрөмж зэрэг нь "Гэрээний нөхцөлөөр бусдад ашиглуулна" гэх шалтгаанаар ашиглалтгүй байна.

Харин "Эрүүл хүнс – малчны хотоос" болон "Орон нутгийн хөгжлийн дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд нийлүүлсэн үржлийн малыг мал аж ахуй эрхлэгч болон үржүүлэг технологийн нэгжүүдэд, зарим арьс шир элдэх төхөөрөмжийг иргэдэд гэрээний дагуу түрээсээр ашиглуулж байна.

Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжээгүй 60.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 33 төсөл, арга хэмжээ байна.

2.39. Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т "Төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг" гэж заасан ч БХБС-ын багцад уг заалтыг хангаагүй ТАХ-г хэрэгжүүлж байна. Өмнөх аудитаар энэ зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн ч хэрэгжүүлээгүй байна. ТАХ-ний мэдээллийг харуулбал:

Хүснэгт 20: Төсвийн хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй ТАХ /тэрбум төгрөг/

ТАХ-ний ангилал	ТАХ-ний тоо	Гэрээний дүн	2022 онд санхүүжүүлсэн дүн
Барилга, байгууламж	17	34.7	10.8
Шилжих	11	25.2	9.9
Шинэ	6	9.4	0.9
Их засвар	14	22.7	6.5
Шилжих	3	3.2	1.7
Шинэ	11	19.5	4.7
Тоног төхөөрөмж	2	2.8	0.5
Шилжих	1	1.0	0.4
Шинэ	1	1.8	0.1
Нийт дүн	33	60.2	17.8

Эдгээр ТАХ-ний хүрээнд:

- Нийтийн орон сууцны гадна фасад янзалсан,
- Гэр хорооллын айлуудын байшинг гадна талаас нь дулаалсан, дотор талд нь халаалт тавьсан,
- Гэр хорооллын айлуудын жорлонг шинэчилсэн,
- Гэр хорооллын айлуудын хашааг сольсон.

Эх сурвалж: БХБЯ-аас авсан ТАХ-ний гүйцэтгэлийн баримт (Дэлгэрэнгүйг хавсралт 6-аас харна уу)

Иргэдийн хувийн хөрөнгөд улсын төсвөөс нийт 60.2 тэрбум төгрөгөөр хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөн хэрэгжүүлж байгаагаас одоогийн байдлаар нийт 36.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлжээ.

Иргэдийн хувийн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалтаар улсын чухал ач холбогдол бүхий санхүүжилт дутагдалтай байгаа ТАХ-үүдийг санхүүжүүлж үр өгөөжийг нь хүртэх боломжийг алдсан байна. Тухайлбал:



- "Дулааны цахилгаан станцын өргөтгөл /Дорнод, Хэрлэн сум" ТАХ-ний Монголын талын хариуцах хөрөнгийн дутууг шийдвэрлэж, уг ТАХ-г хугацаанд нь хэрэгжүүлэх,
- "Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г, д Ø800-ийн гол шугамыг Ø1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөө, барилга угсралтын ажил" ТАХ-ний үлдээгдэл санхүүжилтийг шийдвэрлэж богино хугацаанд төслийг дуусгах,
- "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/ ТАХ-г бүрэн санхүүжүүлэх,
- Нийслэлийн 2 дугаар төрөх "Хүрээ амаржих" газрын барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ ТАХ-г бүрэн санхүүжүүлэх.

Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г ач холбогдол, үр өгөөжөөр нь зөв эрэмбэлдэггүй, санхүүжилтийн эх үүсвэрээр оновчтой хуваарилаагүйг харуулж байна.

2.40. Аудитын дүнд нийт 447.9 тэрбум төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүлээ. Үүнээс 16.0 тэрбум төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 431.8 тэрбум төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Мөн 1 асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэв.

Холбогдох байгууллагуудад хүргүүлсэн нийт албан шаардлагын 40.6 хувь нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй зөрчил байна.

2.41. Өмнөх оны аудитаар нийт 6.5 тэрбум төгрөгийн 24 төлбөрийн акт, 93.3 тэрбум төгрөгийн 23 албан шаардлага, хариуцлага тооцох 1 саналыг хүргүүлснээс 5.9 тэрбум төгрөгийн 18 төлбөрийн акт, 65.2 тэрбум төгрөгийн 14 албан шаардлага хэрэгжсэн байна.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ, САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЯНАХ, ТАЙЛАГНАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2022 онд улсын хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3312 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн байна.

3.1. Орон нутгийн төсөвт хуваарилах орлогын нэр төрлийг Монгол Улсын Төсвийн тухай хуулиар, орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар зохицуулж байна²³.

²³ Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1

3.2. 2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1'832.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3312 төсөл, арга хэмжээг 1,087.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан байна.

3.3. Нийслэл, дүүргийн ИТХ орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,421.9 тэрбум төгрөгийн 1592 төсөл арга хэмжээг нийт 754.8 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр төсөв баталжээ.

3.4. Аймгуудын 2022 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн санхүүжилтийг харьцуулан үзэхэд 0.9–122,3 тэрбум төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөг болон 2022 онд санхүүжүүлэх дүнг ихээх бага байх эрэмбээр ТЭЗ-аар доор үзүүлээ.

Хүснэгт 21: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд батлагдсан төсөв /сая төгрөг/

№	Аймаг, нийслэлийн нэр	ОНТХО-аар хэрэгжих ТАХ-ний		
		Тоо	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн
1	Нийслэл, дүүрэг	1592	1,421,918.1	754,775.0
2	Өмнөговь	439	141,747.2	122,352.9
3	Дорноговь	143	98,602.2	84,052.2
4	Орхон	261	66,390.4	49,028.3
5	Дархан-Уул	214	31,835.5	19,358.2
6	Сэлэнгэ	149	11,267.3	10,473.7
7	Хэнтий	32	13,646.2	8,771.2
8	Төв	19	7,646.7	6,131.7
9	Дорнод	67	7,006.2	5,262.0
10	Говьсүмбэр	49	3,587.9	3,587.9
11	Булган	33	3,553.8	3,103.8
12	Хөвсгөл	38	5,858.6	2,979.2
13	Завхан	31	2,582.9	2,552.9
14	Ховд	22	2,422.5	2,422.5
15	Увс	21	2,422.4	2,422.4
16	Дундговь	41	2,216.4	2,042.0
17	Архангай	49	1,914.3	1,784.3
18	Баянхонгор	25	2,678.9	1,766.5
19	Сүхбаатар	20	1,921.2	1,717.3
20	Говь-Алтай	38	1,538.6	1,323.0
21	Өвөрхангай	11	949.7	949.7
22	Баян-Өлгий	18	1,050.0	900.8
Нийт дүн		3312	1,832,757.0	1,087,757.5

Эх сурвалж: Орон нутаг дах ТАБ-ын ОНХО-ын судалгааны нэгтгэл

3.5. Монгол Улсын эдийн зааг есөхийн хэрээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт ихээр нэмэгдэж байгаа аймгууд байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5.0 тэрбум төгрөгөөс дээш төсөв баталсан нийслэлээс гадна 8 аймаг байна. Тухайлбал, 2022 онд Өмнөговь аймгийн ИТХ-аар 122.3 тэрбум төгрөг, Дорноговь аймгийн ИТХ-аар 84.0 тэрбум,

Орхон аймгийн ИТХ-аар 49.0 тэрбум, Дархан-уул аймгийн ИТХ-аар 19.3 тэрбум, Сэлэнгэ аймгийн ИТХ-аар 10.5 тэрбум, Хэнтий аймгийн ИТХ-аар 8.8 тэрбум, Төв аймгийн ИТХ-аар 6.1 тэрбум, Дорнод аймгийн ИТХ-аар 5.2 тэрбум төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт тус тус баталжээ.

3.6. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг баталсан ИТХ-ын тогтоол нь харилцан адилгүй загвартай байна. Тухайлбал, зарим тогтоол шинэ, шилжих төсөл, арга хэмжээгээр ангилагдаагүй, төсөвт өртөггүй, эхлэх, дуусах хугацаагүй, эдийн засгийн ангилалгүй байна.

3.7. Төсвийн тухай хуулийн 68 зугаар зүйлийн 68.1-т орон нутгийн төсвийг батлахдаа тус хуулийн 33.2.6-д заасныг тусгаж батлахаар заажээ. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад нэр, байршил, хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүнг зааж, хавсралтаар батлахаар тусгасан. Хуулийн энэ заалтыг аймаг бүр харилцан адилгүй хэрэгжүүлж, төсөл арга хэмжээний мэдээллийг дутуу тусгаж баталдаг байна.

3.8. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3²⁴-д тухайн шатны Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг төсвийн төсөлд тусгахдаа санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл, арга хэмжээний нийт өртөг, эхлэх болон дуусах хугацааг төсөл нэг бүрээр бүрэн хэмжээгээр тусгахаар заасан. Гэтэл аймгийн ИТХ-ын тогтоолын төслийг өргөн мэдүүлэхдээ “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг алдаатай төлөвлөж, батлуулсан жишээ олон байна. Жишээлбэл,

Дорноговь аймагт

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 05/04 дугаар тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтын жагсаалтад 2021 онд бүрэн хэрэгжиж дуусаагүй 4.6 тэрбум төгрөгийн 33 төсөл, арга хэмжээг батлаагүй.

- Аймгийн ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 07/03 дугаар тогтоолоор батлагдсан өөрчлөлтөд 2021 онд бүрэн хэрэгжиж дуусаагүй дээрх 33 төсөл, арга хэмжээг 2021 оноос шилжих хөрөнгө оруулалтын 16 төсөл, арга хэмжээтэй давхардуулан баталсан.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорноговь аймагт хэрэгжиж байгаа 57.5 тэрбум төгрөгийн 9 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг тусгаагүй.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Сургуулийн барилга, 640 суудал /Дорноговь, Замын-Үүд сум/” төсөл, арга хэмжээд орон нутгийн төсвөөс 10.2 тэрбум төгрөг буюу батлагдсан төсвөөс 0.7 тэрбум төгрөгийг 2022 онд илүү олгохоор баталсан.

Өмнөговь аймагт

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын тогтоолын хавсралтаар төсөл, арга хэмжээний мэдээлэл дутуу баталдаг байна.

2022 ОНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИЖ БАТАЛСАН ТӨСӨВ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

№	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	Хэрэгжүүлэх жил	Төсөвт өртөг (сая.төг)	2022 онд санхүүжүүлэх дүн (сая.төг)	Төлөвлөгөөний төсөвт өртөг (сая.төг)	Төлөвлөгөөний санхүүжүүлэх дүн (сая.төг)
НИЙТ ДҮН						
1	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2022	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
2	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2021	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
3	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2020	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
4	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2019	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
5	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2018	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
6	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2017	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
7	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2016	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
8	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2015	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
9	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2014	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
10	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2013	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
11	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2012	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
12	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2011	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
13	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2010	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
14	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2009	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
15	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2008	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
16	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2007	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
17	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2006	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
18	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2005	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
19	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2004	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
20	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2003	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
21	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2002	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
22	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2001	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
23	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	2000	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
24	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	1999	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
25	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	1998	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
26	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	1997	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
27	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	1996	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
28	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	1995	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
29	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	1994	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
30	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	1993	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
31	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	1992	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
32	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	1991	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0
33	Төсөл, арга хэмжээний нэр (уламжлал, байршил)	1990	128,000.0	128,000.0	128,000.0	128,000.0

²⁴ 29.3.4. санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;

Аймаг, сумдын ИТХ орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх төсөл, арга хэмжээний Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасан хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжилтийн эх үүсвэрийн мэдээллийг дутуу баталсан байна.

Орхон аймагт

Аймгийн ИТХ-н тогтоолыг 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 09/05 дугаар тогтоол, 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 10/02 дугаар тогтоол, 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 11/03 дугаар тогтоолоор нийт 3 удаа тодотгожээ.

Анх баталсан тогтоолоос сүүлд тодотгон батлахдаа шилжих хөрөнгө оруулалтын ТАХ-ний тоог нэгээр бууруулсан ч санхүүжүүлэх дүн 5.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн, шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний тоог 30-аар нэмэгдүүлж, санхүүжүүлэх дүнг 1.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Зураг төсвийн зардал болон болзошгүй аваарын зардлыг төсөвт багцалсан дүнгээр баталдаг байна. /зураг төсөв-10, болзошгүй аваарын зардал-52 ажил болон задарсан байна.

Булган аймаг

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх 3.5 тэрбум төгрөгийн 33 төсөл, арга хэмжээг баталснаас Төсвийн тухай хуулийн 29.4¹ -д нийцүүлэн төлөвлөөгүй 1.0 тэрбум төгрөгийн 16 төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлжээ.

Барилга байгууламжийн 0.1 тэрбум төгрөгийн 2, тоног төхөөрөмжийн 0.2 тэрбум төгрөгийн 7, их засварын 0.6 тэрбум төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг зураг, төсөв, ТЭЗҮ хийгдээгүй ажлыг төсөвт тусгасан нь хөрөнгө оруулалтын батлагдсан төсвийн 28.2 хувийг төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ байна.

3.9. Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29¹.1-д төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүдийг эрэмбэлэн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг бэлтгэхээр заасан байдаг ч хууль, тогтоомжид заасан шалгуур, нөхцөлийн дагуу хөрөнгө оруулалтыг төлөвлөөгүй, төлөвлөлтийн шатанд хийгдсэн баримт, материал байхгүй байгаа нь шаардлага хангаахааргүй байна. Өөрөөр хэлбэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөв боловсруулж байгаа үндсэн нэгж хуулийн дагуу төлөвлөдөггүй, түүнд тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөв батлагдаж байна.

3.10. Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4-т төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, эх үүсвэр бүрээр нь батлахаар заасан. Орон нутгийн ИТХ төсвийг Төсвийн тухай болон Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шаардлага хангасан эсэхийг үл хамааран баталдаг байна. Төсөв боловсруулж батлах үеийн дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

3.11. 2022 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 34 хувь нь 1370.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, тайлант онд 703.6 тэрбум төгрөгөөр санхүүжих 1129 төсөл, арга хэмжээ бүхий барилга байгууламж, 24 хувь нь 155.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, тайлант онд 118.7 тэрбум төгрөгөөр санхүүжих 779 төсөл, арга хэмжээ бүхий их засвар, 28 хувь нь 214.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, тайлант онд 196.5 тэрбум төгрөгөөр санхүүжих 934 төсөл, арга хэмжээ бүхий тоног төхөөрөмж, 12 хувь нь 89.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 65.3 тэрбум төгрөгөөр санхүүжих 398 ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах төсөл арга хэмжээг тус тус төлөвлөжээ. Үлдсэн 2 хувь болох 2.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 3.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх 72 төсөл, арга хэмжээ нь хөтөлбөр болон хөрөнгө оруулалтын бус төсөл арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 22. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ангилал /тэрбум төгрөг/

Төсөл, арга хэмжээний ангилал	ОНТХО-аар хэрэгжсэн ТАХ-ний		
	Нийт тоо	Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн
Барилга байгууламж	1,129	1,370.8	703.6
Их засвар	779	155.4	118.7
Тоног төхөөрөмж	934	214.2	196.5
ТЭЗҮ, зураг төсөл	398	89.4	65.3
Бусад	72	2.9	3.6
Нийт дүн	3,312	1,832.7	1,087.7

Эх сурвалж: Орон нутаг дах ТАБ-ын ОНТХО-ын судалгааны нэгтгэл

3.12. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянах нэгдсэн арга зүй байхгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт улсын болон орон нутгийн хөгжлийн бодлогыг дэмжиж байгаа гэх үндэслэл хангалтгүй байна

3.13. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн төлөвлөхөөр 2015-2020 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, 2020 оноос Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар зохицуулсан байна.

3.14. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7-д дунд хугацааны баримт бичгийн талаар нарийвчлан заасан бөгөөд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн баримт бичиг нь Засгийн газрын болон Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна гэж заасан.

3.15. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 90 орчим хувь нь хөгжлийн бодлогын урт болон дунд хугацааны баримт бичгүүдтэй нийцэж байгаа гэсэн дүн гарсан. Гэвч төсөл, арга хэмжээг аймаг, нийслэл хотын хөгжлийн зорилтыг хангах зорилгоор төлөвлөж байгаа эсэх нь учир дутагдалтай байна. Тухайлбал, дунд хугацааны батлагдсан бодлогын баримт бичиг нь тавьсан зорилго, зорилтод хүрэхийн тулд тооцсон хэрэгжүүлэх арга хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэр, хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх зорилтот түвшин зэрэг нь бүрэн тодорхойлогдоогүй байна.

3.16. Орон нутагт дунд хугацааны бодлогын баримт бичигтэй бүрэн нийцүүлж төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлдэггүйгээс Засгийн газрын үйл ажиллагаа орон нутагт бүрэн хэрэгжихгүй байх нөхцөлд хүргэсэн байна. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын улсын хэмжээний нэгдсэн дүн гардаггүй, орон нутагт хэрэгжсэн төсөл, арга хэмжээний мэдээлэл бодлогын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад байхгүй байгаа нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт бодлогын уялдаагүй хэрэгждэг гэж үзэхээр байна.

3.17. 2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь "Алсын хараа-2050" бодлогын баримт бичгийн дээрх зорилтуудын хүрээнд хэрэгжсэн мэт харагдах боловч уг бодлогын баримт бичигт заасан суурь, түвшин, тодорхой үе шатуудад хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, тэдгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нийцэхгүй байна.

3.18. Дээрх дунд хугацааны бодлогын баримт бичиг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд²⁵ заасан үр дүнд чиглэсэн шалгуур үзүүлэлт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, зорилгот түвшнийг тооцож боловсруулсан байх шаардлага болон судалгаа, шинжилгээнд үндэслэсэн зарчмыг баримтлаагүй байна.

3.19. Засгийн газрын 2018 оны 20 дугаар тогтоолоор орон нутгийн хөгжлийн ерөнхий түвшнийг тодорхойлох, хөрөнгө оруулалтыг аймаг, орон нутгийн хөгжлийн бодит түвшинд тулгуурлан оновчтой төлөвлөх зорилгоор "Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал"-ыг баталсан. Төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн индексийг харгалзан бүрэн төлөвлөхгүй байгаа нь хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичиг үр дүнгүй болоход нөлөөлж байна.

3.20. Үндэсний хөгжлийн газрын 2021 оны А/41 дүгээр тушаалаар баталсан "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх" журмын 3.4-д "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны төрийн болон орон нутгийн захиргааны бүх шатны байгууллага нь Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл бүрдүүлэгч байна" гэж заасан байна.

3.21. Мөн Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсын Засгийн газарт үзүүлж буй буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлсэн "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх төсөл"-өөр www.development.gov.mn цахим системийг боловсруулж, хүлээлгэн өгсөн ч уг цахим системийн хөгжүүлэлтийг огт хийгээгүйгээс орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнгийн мэдээлэл оруулах боломж бүрдээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 60 хувь нь бүрэн хэрэгжиж дууссан байна.

3.22. 2022 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 3312 төсөл, арга хэмжээг 1087.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 715.4 тэрбум тэрбум төгрөг буюу төлөвлөсөн санхүүжилтийн 65.8 хувийг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 23: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөв, гүйцэтгэлийн харьцуулалт /сая төгрөг/

Орон нутгийн нэр	ОНТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний		2022 онд олгосон санхүүжилт	Хэрэгжиж дууссан ТАХ-ний тоо
	Нийт тоо	Тухайн онд санхүүжих төсөв		
Нийслэл	1592	754,775.0	483,171.2	566
Өмнөговь	439	122,352.9	99,215.2	310
Орхон	261	49,028.3	40,781.2	201
Дорноговь	143	84,052.2	30,808.7	118
Дархан-Уул	214	19,358.2	14,513.5	189
Сэлэнгэ	149	10,473.7	8,699.2	114
Хэнтий	32	8,771.2	8,169.7	28
Төв	19	6,131.7	4,118.4	13
Дорнод	67	5,262.0	3,943.1	55
Булган	33	3,103.8	2,433.7	28
Говьсүмбэр	49	3,587.9	2,411.0	34
Хөвсгөл	38	2,979.2	2,377.6	30
Ховд	22	2,422.5	2,127.2	19

²⁵ 6.8.4.6.үр дүнд чиглэсэн шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, зорилгот түвшинг тооцож боловсруулсан байх

Увс	21	2,422.4	2,099.0	17
Дундговь	41	2,042.0	1,948.6	38
Архангай	49	1,784.3	1,725.0	49
Баянхонгор	25	1,766.5	1,637.8	19
Завхан	31	2,552.9	1,518.0	25
Сүхбаатар	20	1,717.3	1,161.9	14
Говь-Алтай	38	1,323.0	1,123.5	27
Өвөрхангай	11	949.7	897.5	10
Баян-Өлгий	18	900.8	560.5	14
Нийт дүн	3312	1,087,757.5	715,441.5	1918

Эх сурвалж: Орон нутаг дах ТАБ-ын ОНХО-ын судалгааны нэгтгэл

3.23. 3312 төсөл, арга хэмжээний 1918 буюу 60 орчим нь бүрэн хэрэгжиж, үлдэх хэсэг нь дараа онд шилжихээр болсон байна. Шалтгаан нь худалдан авах ажиллагааг оройтож зарласан, сонгон шалгаруулалтад оролцогч ирээгүй, төлөвлөсөн санхүүжилт бүрдээгүй учраас хойшлуулсан, барилга байгууламжийг он дамжуулан барихаар төлөвлөсөн зэргээс хамаарсан байна.

3.24. 2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 409 барилга байгууламж, 532 их засварын ажил 681 тоног төхөөрөмж, 240 ТЭЗҮ, зураг төсөл, 56 хөрөнгө оруулалтын бус төсөл арга хэмжээ хэрэгжиж дууссан байна.

Хүснэгт 24: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болон хэрэгжсэн төсөл арга хэмжээний дүн /тэрбум төгрөг/

Хөрөнгө оруулалтын ангилал	ОНТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний		2022 онд олгосон санхүүжилт	Хэрэгжиж дууссан ТАХ-ний тоо
	Нийт тоо	Тухайн онд санхүүжих төсөв		
Барилга байгууламж	1,129	703.6	455.8	409
Их засвар	779	118.7	92.3	532
Тоног төхөөрөмж	934	196.5	138.9	681
ТЭЗҮ, зураг төсөл	398	65.3	26.3	240
Бусад	72	3.6	2.1	56
Нийт дүн	3,312	1,087.7	715.4	1,918

Эх сурвалж: Орон нутаг дах ТАБ-ын ОНТХО-ын судалгааны нэгтгэл

3.25. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээнд дараах нийтлэг зөрчил гарсан байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т хөрөнгө оруулалт нь "... орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлага" гэж заасан. Гэтэл энэхүү заалттай нийцэхгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн.
- Захиалагч нь тендэрт оролцогчийн мэдвэл зохих шаардлагатай бүх мэдээллийг тендерийн баримт бичигт тусгаж, өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж зохион байгуулж болохоор заасан байхад худалдан авах ажиллагааг багцад хувааж өрсөлдөөнийг дэмжээгүй, мэдээллийг бүрэн тусгаагүйгээс шалтгаалж нийлүүлсэн бараа, материал нь ашиглалтын

шаардлага хангахааргүй, хүлээн авах тоо хэмжээ нь тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгэсэн

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тухайн ААНБ-ын санхүү, хүний нөөц, техник хэрэгслийн чадамжийг бүрэн үнэлдэггүйгээс олон төсөл, арга хэмжээ нэг ААНБ гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажилласан байна. Энэ нь төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх, чанаргүй гүйцэтгэх зэрэг эрсдэлийг үүсгэж байна.
- Чанарын шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн.
- Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-д заасныг зөрчиж, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг бүрэн хянаагүй, батлагдсан төсөвт тусгаагдаагүй болон дуусаагүй ажилд санхүүжилтийг олгосон
- Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэж заасан. Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба 2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгээгүй.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд нийт 495 төсөл, арга хэмжээ хэрэгжсэний үр дүнд боловсрол, соёл, спортын 139, эмнэлгийн 18 барилга, шинээр барих болон шинэчлэх цэвэр бохир усны 143.8 км, дулааны 30.3 км шугам, ЦДАШ 483.2 км шугам, 169 км авто зам тус тус ашиглалтад орсон байна. (Тайлангийн 2.7)
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүйгээс 2022 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүн нь тайлант оны зорилтдоо хүрсэн эсэх, зөргө өөрчлөлт бий болгосон эсэхийг үнэлэх боломжгүй байна. (Тайлангийн 1.6-1.10)
- Анхан шатны нэгжээс Төсвийн ерөнхийлөн захирагч, орон нутгаас салбарын Ерөнхийлөн захирагч хүртэлх ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаагаас эрэмбэлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй, хууль, журамд нийцээгүй төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээ төлөвлөгдөж, төсвөөс үргүй зардал гарах суурь шалтгаан болж байна. (Тайлангийн 1.11-1.16, 1.24)
- Төсөл арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг бодитой тодорхойлоогүй, үр дүнтэй болохыг тогтоогоогүй, ТЭЗҮ-г "Шаардлагатай төсөл, арга хэмжээнд хийнэ" гэсэн үндэслэлээр орхигдуулж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна. (Тайлангийн 1.17-1.23)
- Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг оновчтой хуваарилаагүйгээс чухал шаардлагатай төслийн үр өгөөж хойшилж, ач холбогдол багатай, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй хөрөнгө оруулалт хэрэгжиж байна. (Тайлангийн 2.10-2.13, 2.39)
- Хэрэгжүүлсэн зарим зураг, төсөл, тоног төхөөрөмжийг ашиглахгүй байгаагаас ашиглалтын шаардлага хангахгүй болж төсвөөс үргүй зардал гарах нөхцөлийг үүсгэж байна. (Тайлангийн 2.20, 2.33-2.38)
- Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагч, зохиогчийн хяналт үр дүнгүй, Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж Төсвийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт хийхгүй байгаагаас зөрчил буурахгүй байна. (Тайлангийн 2.26-2.29)
- Орхигдсон болон олон жил үргэлжилж байгаа төсөл, арга хэмжээг богино хугацаанд ашиглалтад оруулах шийдлийг гаргаж чадахгүй байгаагаас төсвийн 287.6 тэрбум төгрөг үргүй зарцуулагдах эрсдэлтэй байна. (Тайлангийн 1.31-1.33)
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, түүнийг хянах дотоод хяналт хангалтгүйгээс төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөхгүй байна. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад нэр, байршил, хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүнг иж бүрэн тусгахгүйгээр баталж байна. (Тайлангийн 3.7-3.8)
- Төсвийн хөрөнгө оруулалтыг улсын болон орон нутгийн хөгжлийн дунд хугацааны бодлоготой нийцүүлж боловсруулах нэгдсэн удирдлага, зохион байгуулалт хангалтгүйгээс иргэд төрийн үйлчилгээг ил тод, шуурхай хүртэх, нийгмийн үнэ цэнэ нэмэгдүүлэх, иргэдийн амьдралыг дээшлүүлэхээр орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр нөлөөг тооцох боломжгүйд хүргэж байна. (Тайлангийн 3.10, 3.13-3.18)

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдад:

1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тухайн жилийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжигдэхүйц болгож, шинэчлэн сайжруулах,
2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн жил дамжуулан Төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах эрх олгосон шийдвэр гаргахгүй байх,
3. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ төлөвлөгөө зөрчлийг давтан гаргасаар байгаа Төсвийн ерөнхийлөн захирагч нарт хариуцлага тооцох.

Эдийн засгийн хөгжлийн сайдад:

1. Урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг дэмжих хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгцээ, шаардлагыг бодитой тодорхойлж эрэмбэлсэн улсын хэмжээний нэгдсэн судалгаа, мэдээллийн сантай болох,
2. Төсөл, арга хэмжээний үр ашиг, ач холбогдлыг үнэн зөв, бодитой тооцоолохгүй байгаад дүгнэлт хийж шалтгааныг тодруулан шаардлагатай арга хэмжээг авах,

Сангийн сайдад:

1. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем www.publicinvestment.gov.mn/-д төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн мэдээллийг үнэн зөв байршуулсан эсэхэд хяналт шалгалт зохион байгуулж, хангалтгүй хэрэгжүүлж байгаа албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг дээд шатны удирдлагад хүргүүлэх,
2. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн монголын талын хөрөнгө оруулалтын шаардагдах нийт хөрөнгийн дүн, үргэлжлэх хугацааг төсөл, арга хэмжээ бүрээр тодорхой төлөвлөн баталж байгаа шийдвэрт тусгах,
3. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий цөөн төсөлд хуваарилж, богино хугацаанд хэрэгжүүлэх,
4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх, хянах, тайлагнах тухай журам, заавар боловсруулж орон нутагт нэвтрүүлэх,
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг түлхүүр гардуулах нөхцөлөөр төлөвлөж хэрэгжүүлж байгаа эрх зүйн орчныг боловсронгуй болгож, Төсвийн тухай хуульд нийцүүлэн ТБОНӨХБАУХАТ хуульд өөрчлөлт оруулах саналыг эрх бүхий байгууллагад уламжлах

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилтийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль болон холбогдох хууль, журам, заавар, аргачлалыг чанд мөрдөж ажиллах,

2. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем www.publicinvestment.gov.mn/-д төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн мэдээллийг үнэн зөв, үндэслэлтэй байршуулах,
3. Төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг холбогдох аргачлалын дагуу төсөл, арга хэмжээ тус бүрээр тооцоолж, шаардлагатай зардлын тооцоо, төсөвт нөлөөлөх ачааллын дүгнэлтийг гаргах,
4. Улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээнд төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх,
5. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод аудитын нэгжээр тогтмол хяналт хийлгэж, үр дүнг тухай бүр үнэлж байх.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд тусгасан төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангаж буй эсэхэд хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хяналт тавих.

Аймгийн Засаг дарга нарт:

1. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем www.publicinvestment.gov.mn/-д төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн мэдээллийг үнэн зөв, үндэслэлтэй байршуулах,
2. Орон нутгийн төсвийг төлөвлөлт, судалгаа хариуцсан албан хаагчдыг ЗГХЭГ-ын дэргэдэх Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн "Хөгжлийн болон төрийн бодлого төлөвлөлт хийх арга зүй"-н сургалтад хамруулж, мэдлэг, үр чадвар, чадавхыг сайжруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 267468, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.05.31 № 02/3843

төний _____ -ны № _____ -т

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧИЙН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.НАРАНЧИМЭГ ТАНАА**

Танаас ирүүлсэн "Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитын тайлангийн төсөлд санал авах тухай албан бичигтэй танилцлаа.

Аудитын тайлангийн төсөлд тусгах саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт...6...хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА  Ж.ГАНБАТ

3765002056

"Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь хэрэгцээ шаардлага, эдийн засгийн үр ашиг багатай олон жижиг арга хэмжээнд чиглэгдсэн байна"-гэснийг шинэчлэн найруулах;

Тайлбар
1-г харна
уу

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, УИХ-аас баталсан 5 жилийн үндсэн чиглэл, Алсын хараа 2050 хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан, нийгэм, эдийн засаг, иргэдийн бодит хэрэгцээнд тулгуурласан төсөл, арга хэмжээнүүдийг Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, журмын дагуу төлөвлөж, санхүүжүүлдэг

Тайлбар
2-г харна
уу

"Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийн ихэнх нь төлөвлөлтийн шаардлага хангахгүй байна"-гэснийг өөрчлөх;

2022 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг төсвийн ерөнхийлөн захирагчаас улс төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем /www.publicinvestment.gov.mn/-ээр хүлээн авч Төсвийн тухай хууль болон холбогдох журмын дагуу үнэлж, эрэмбэлэн Засгийн газарт өргөн мэдүүлж, УИХ-аар батлуулдаг

Тайлбар
3-г харна
уу

"Барилга байгууламж, их засварын ангилалд шинээр хэрэгжүүлэх 502 төсөл, арга хэмжээнээс 406 нь магадлалгүй батлагдсан байна"-гэснийг эргэж нягтлах;

"Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэх 664 төсөл, арга хэмжээнээс барилга байгууламж, их засвар ангилалд 502 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс 81 хувь буюу 406 төсөл, арга хэмжээ нь магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй батлагдсан байна.", эдгээрээс магадлалын хугацаа дууссан 17 төсөл, арга хэмжээ байгаа талаар дурдсан байна. Тайлангийн хавсралт №1-с харахад 2019 онд 6 төсөл, арга хэмжээний магадлалын ерөнхий дүгнэлт баталгаажсан байх тул Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 291.2.2-т "Барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх" гэж заасны дагуу 2022 оны төсвийн төслийг 2021 онд төлөвлөхөд 2019, 2020 оны магадлалыг уг шаардлагыг хангана гэж тооцож байгаа тул эдгээр төслүүдийг эргэж нягтлах шаардлагатай байна

Тайлбар
4-г харна
уу

"Гаалийн хяналт, шалгалт бүрдүүлэлтийн барилга /Увс, Улаангом/-гэснийг хасах;

МУ-ын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Гаалийн шинэчлэл" төслийн хүрээнд Увс аймгийн гаалийн хяналт, бүрдүүлэлтийн барилгыг 2022 оны төсвийн тухай хуульд тусгахдаа ашиглагч байгууллагаас ирүүлсэн санал, зураг төсөл зохиогчоос ирүүлсэн магадлалыг харгалзан 1.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр тусгасан. Харин 2023 онд тус барилга байгууламжийн цахилгаан, дулааны техникийн нөхцөл өөрчлөгдсөнтэй холбоотой нэмэлт ажлын магадлал нийт 2.6 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр батлагдсан байна

Тайлбар
5-г харна
уу

"Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг оновчтой хуваарилгаагүй байна"-гэсэнд тайлбар хүргүүлэх;

Төвийн тухай хуулиар батлагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Төсвийн тухай хууль, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн саналыг харгалзан мөн тухайн жилийн эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн орлого бүрдүүлэлттэй уялдуулан аль болох богино хугацаанд, үр дүнтэйгээр санхүүжүүлэхээр төлөвлөж баталдаг

Тайлбар
6-г харна
уу

"Уг ТАХ-ний гүйцэтгэгчээр "ТВЕА" ХХК шалгаран ажиллаж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 42.3 хувьтай ч санхүүжилтийн 22 хувийг олгосон байна"-гэснийг хасуулах;

Монгол улсын ЗГ болон БНХАУ-ын хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Дулааны цахилгаан станцын өргөтгөл /Дорнод, Хэрлэн сум/" төсөл, арга хэмжээний Монгол талын хариуцах санхүүжилтийг 2020-2024 онд 52.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тусгаж, нийт 16.0 тэрбум төгрөг буюу 32.5 хувийн Монгол талын санхүүжилтийг

	<p>гүйцэтгэлээр олгосон бөгөөд харин БНХАУ-ын хөгжлийн банкны санхүүжилтээс шалтгаалан төслийн бүтээн байгуулалтын ажил удаашралтай байгаа тул хасуулах</p> <p>"Дархан-Шарын гол чиглэлийн авто замын трасст өөрчлөлт оруулсан байж болзошгүй"-гэснийг хасах;</p> <p>Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2020 он үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.8 /Дархан-Шарын гол чиглэлийн авто замыг хатуу хучилттай болгоно/, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1.1 /Дархан-Шарын гол чиглэлийн авто замыг хатуу хучилттай болгох ажлыг хийж гүйцэтгэх/, 2.6.1.3 Аргалын гармаас "Зулзагын гол" хүүхдийн зуслан хүртэл 10км замыг хатуу хучилттай болгох ажил тусгагдсан. Дархан-Шарын гол чиглэлийн авто замын зураг төсвийг анх 2013 онд боловсруулсан Мөнхийн тод зам ХХК боловсруулж Барилгын хөгжлийн төвөөр Магадлал хийгдэж байсан. Зураг, төсөвт боловсруулагдсанаас хойш олон жил болж, техникийн нөхцөлүүдийг шинэчлэх, иргэдээс ирсэн хүсэлт, бодлогын бичиг баримтуудтай уялдуулан 2019, 2021 онуудад зураг, төсөв шинэчлэгдэж Зам тээврийн хөгжлийн төв Магадлал хийгдсэн</p>
Тайлбар 7-г харна уу	
Тайлбар 8-г харна уу	<p>"Монгол талын хариуцах хөрөнгө оруулалтын дүн, ямар хугацаанд хэрэгжих нь тодорхойгүй батлагдаж байна. Мөн зарим хөрөнгө нь хөрөнгө оруулалтын шинж чанаргүй байна, тухайлбал БНХАУ-ын тусламжаар хэрэгжиж буй 1008 айлын орон сууц барих төслийн хүрээнд газар чөлөөлөлтийн нөхөн олговор олгосон"-гэсэнд тайлбар хүргүүлэх;</p> <p>Монгол Улсын Засгийн газар, Олон улсын санхүүгийн байгууллага хөгжлийн түнш бусад орны Засгийн газартай байгуулсан олон улсын зээлийн хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний Монголын талын хүлээх үүрэг хариуцлагын заалтын дагуу хийгдэх санхүүжилтийг ОУ-ын гэрээ, хэлэлцээрийн дагуу төсөвт тусган санхүүжилтийг хийдэг тул төсөл хэрэгжиж дуусах хүртэл хугацаанд гарсан бүхий л холбогдох зардлууд тухайлбал дэд бүтэц, газар чөлөөлөлт зэргийг Монголын тал хариуцан шийдвэрлэдэг. Мөн шинэ төсөл эхлүүлэх, хэлэлцээр хийх хугацаа хөгжлийн түнш, олон улсын байгууллагын шаардлага, процессоор явдаг тул хугацаа орох, Монголын талын хөрөнгийг ашиглахгүй дараа онуудад шилжих тохиолдол их байдаг.</p> <p>БНХАУ-н Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт 2016 онд өгөхөөр амласан нийт 1.0 тэрбум юанийн буцалтгүй тусламжийн хүрээнд байгуулсан олон улсын гэрээ, талуудын байгуулсан "Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн орон сууцны бүтээн байгуулалтад тусламж үзүүлэх тухай төсөл хэрэгжүүлэх протокол"-ын 3.2.2-д төсөл хэрэгжихээс өмнө Монгол Улсын тал газар чөлөөлөлтөө бүрэн хариуцан, барилга барих газрыг бэлэн болгож, ... иргэдийг нүүлгэн шилжүүлж, төслийн талбайг бэлтгэсэн байх үүрэг хүлээсэн болно. Мөн Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас нийслэлийн төсвийн орлого бүрдүүлэлт багасаж, Нийслэлийн зүгээс төсөл хэрэгжиж байгаа байршилд газар чөлөөлөлттэй холбоотой зардлыг шийдвэрлэх боломжгүй болсныг удаа дараа Засгийн газарт танилцуулсан. Иймд Монгол улсын 2021 оны төсвийг Засгийн газраар хэлэлцэх үед газар чөлөөлөлттэй холбоотой хөрөнгийг шийдвэрлэхээр болж, улсын төсвийн хөрөнгө оруулалтад 2021 оноос эхлэн хөрөнгийг тусган шийдвэрлэсэн. Газар чөлөөлөлтийн хөрөнгө хугацаандаа шийдвэрлэгдсэний үр дүнд Монгол улс хариуцсан үүргээ биелүүлж БНХАУ-ын Засгийн газраас 347.4 сая юань буюу 170.0 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламжийг Монгол Улсын Засгийн газарт үзүүлэхээр болж төсөл нь амжилттай хэрэгжиж байна. Төслийг хэрэгжүүлснээр гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд агаарын бохирдол, хөрсний бохирдлыг бууруулах, иргэдийн амьдрах орчныг сайжруулах, гэр хорооллыг орон сууцжуулах 21 давхар 8 блок 1008 айлын барилга барих, мөн орчны тохижилт, зам талбайг бүрэн тохижуулах, автомашины ил зогсоолтой иж бүрэн төсөл хэрэгжинэ. Мөн тус төсөл нь Засгийн газрын 2016 оны 174-р тогтоолоор баталсан "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага" баримт бичиг, МУ-ын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ний өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн ... 9.3.2.хот</p>

дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх заалт болон МУ-ын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн ...7.9.Хуримтлалын нэгдсэн санг байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150 мянган өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барих ажлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан үе шаттай эхлүүлнэ гэсэн бодлоготой тус тус уялдан хэрэгжиж байна. Түүнчлэн газар чөлөөлөлтийн асуудал зөвхөн энэ төсөл төдийгүй АХБ-ны санхүүжилттэй бусад нийслэлд хэрэгжиж байгаа төслүүдэд тулгамдсан асуудал болж, зээлдэгчид саналыг хүргүүлснээр зээлийн хөрөнгөөс газар чөлөөлөлтөө шийдэж байгаа тохиолдлууд ч бий. Тухайлбал, 2021-2022 онуудад хэлцэл хийснээр, 2022 онд АХБ-ны зээлийн хөрөнгөөс газар чөлөөлөлтөд 16.1 тэрбум төгрөг олгосон бол, 2023 онд 17.5 тэрбум төгрөг олгож байна. /Нийслэлээс газар чөлөөлөлттэй холбоотой ирүүлсэн тайлбар, хүсэлт албан бичгүүдийг хавсаргав/ Уг төслийн хүрээнд олгосон газар чөлөөлөлтийн хөрөнгөөр чөлөөлсөн газрыг холбогдох ТЭЗ нь өөрийн данс, бүртгэлд бүртгэж капиталжуулж байгаа тул уг хэсгийг тайлангийн төслөөс хасах

Тайлангийн зөвлөмжийн Сангийн сайдад гэсэн хэсгийн 1-т заасан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн цахим систем /www.publicinvestment.gov.mn/-нд төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг үнэн зөв, бодитой байршуулахад холбогдох албан хаагчдыг арга зүйгээр ханган, мэдээллийн найдвартай байдалд хяналт тавих"- зөвлөмжид;

Сангийн яам Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж байгаа "Төсөв, санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл"-ийн хүрээнд "Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг" сургалтыг 2023 оны 2 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд сургалт, хэлэлцүүлгийг 9 дэх удаагаа амжилттай зохион байгуулсан. Сургалтад яам, агентлаг, нийслэл, аймгуудаас 300 гаруй оролцогч оролцсон. Сургалтаар төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналтын үе шатанд улсын төсвийн хөрөнгө оруулалтын одоогийн байдал, тулгамдаж байгаа асуудлуудыг сонсох, хөрөнгө оруулалтын шинжилгээний аргачлал, цахим систем, олон улсын сайн туршлагын талаар мэдээлэл хуваалцаж, үр ашгийг сайжруулах арга зам, цаашид хэрэгжүүлэх арга хэрэгжээний талаар танилцуулсан. Системд шинээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар (ОНТ) хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж буй болон төлөвлөж буй төслүүдийн мэдээллийг оруулах, улмаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй нэгтгэн харах, төлөвлөхтэй холбогдуулан системд ОНТ дэд систем үүсгэж, төсөл бүртгэх, төлөвлөх хэсгийн хөгжүүлэлтийг хийж дуусгасан бөгөөд холбогдох мэдээллийг нийслэл, бүх дүүрэг болон аймгийн хөрөнгө оруулалтын мэргэжилтэн, албан хаагчдад танилцуулсан.

Тайлбар 9-г харна уу

Мөн дээрх "Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг" сургалтын хүрээнд "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем /PIMIS/-ийн шинэчлэгдсэн хувилбарыг танилцуулах бүсчилсэн сургалтыг зохион байгуулсан. Үүнд:

1. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем /PIMIS/-ийн талаарх Зүүн бүсийн сургалтыг 2023 оны 3 дугаар сарын 23-наас 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд Хэнтий аймагт Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн холбогдох албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан.
2. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем /PIMIS/-ийн талаарх Дорноговь аймагт Говийн бүсийн сургалтыг 3 дугаар сарын 31-нээс 4 дүгээр сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд сургалтад Төв, Говьсүмбэр, Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн холбогдох албан хаагчид оролцсон.
3. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем /PIMIS/-ийн талаарх Төвийн бүсийн сургалтыг 2023 оны 4 сарын 7-ноос 8-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл, Булган аймгийн холбогдох албан тушаалтнуудад зохион байгуулсан.

4. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем /PIMIS/-ийн талаарх Баруун бүсийн сургалтыг 2023 оны 4 дүгээр сарын 20-ноос 21-ний өдрүүдэд Ховд аймагт зохион байгуулсан бөгөөд
5. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем /PIMIS/-ийн талаарх Агентлагуудын сургалтыг 2023 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр төсвийн хөрөнгө оруулалт, гүйцэтгэл хэрэгжилт хариуцсан албан хаагчдад зориулсан сургалтыг зохион байгуулсан.

Мөн дээрх сургалтуудаас гадна PIMIS системийг хөгжүүлэгч багын зөвлөхүүд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч, захиалагч буюу ТЕЗ-ийн хөрөнгө оруулалт хариуцсан албан тушаалтнууд болгонтой харилцаж тус цахим системд хэрхэн төлөвлөлтийн шатнаас эхлэн санхүүжилтийн эрх нээх хүртэлх талаарх заавар зөвлөгөө өгч ажилладаг. Тийм учраас тус аудитын тайлангийн төсөлд Сангийн сайдад зөвлөмжөөр өгөгдсөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн цахим систем /www.publicinvestment.gov.mn/-нд төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг үнэн зөв, бодитой байршуулахад холбогдох албан хаагчдыг арга зүйгээр ханган, мэдээллийн найдвартай байдалд хяналт тавих гэсэн зөвлөмжийг хасуулах саналтай байна.

Тайлангийн зөвлөмжийн Сангийн сайдад гэсэн хэсгийн 2-т заасан "Төсөл арга хэмжээний бэлтгэл хангах" арга хэмжээ;

Тухайн жилийн төсөв батлагдсаны дараа урьдчилан төлөвлөх боломжгүй давагдашгүй болон гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр зайлшгүй шаардагдах болзошгүй зардлыг санхүүжүүлэх шаардлагаар "Төсөл арга хэмжээний бэлтгэл хангах" зардал Сангийн сайдын багцад батлагддаг. Өөрөөр хэлбэл давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан болон онцгой шаардлагатай төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тухайн зардлаас санхүүжүүлсэн. Тухайлбал, Төв аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын барилга шатсан тул батлагдсан барилгын зургийн дагуу уг шатсан барилгад их засвар хийх, Монгол Улсын Засгийн газрын Шинэ сэргэлтийн бодлого-боомтын шинэчлэлийн хүрээнд Хилийн боомтуудын бүтээн байгуулалтын ажил дуусаж ашиглалтад орох үед нэн шаардлагатай тоног төхөөрөмж, тохижилт, тавилга хэрэгсэл, зарим хилийн боомтуудын телехяналтын камерыг нэмэгдүүлэх, түүнчлэн Төмөр зам доогуурх жижиг оврын авто машин гаргах хонгилын гарц гаргах зардал зэргийг шийдвэрлэсэн тул хасах.

Тайлбар
10-г
харна уу

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Сангийн яамнаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Тайлбар 1	Нотлох баримтаар дэмжигдсэн тул саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар 2	Нотлох баримтаар дэмжигдсэн тул саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар 3	Нотлох баримтаар дэмжигдсэн тул саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар 4	Нотлох баримтаар дэмжигдсэн тул саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар 5	Нотлох баримтаар дэмжигдсэн тул саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар 6	Нотлох баримтаар дэмжигдсэн тул саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар 7	Саналыг хүлээн авч өөрчлөлт оруулсан. Шинээр ирүүлсэн нотлох баримтад үндэслэн "БНХАУ-ын тусламжаар хэрэгжиж буй
Тайлбар 8	1008 айлын орон сууц барих төслийн хүрээнд газар чөлөөлөлтийн нөхөн олговор олгосон"-той холбоотой хэсгийг тайлангаас хаслаа.
Тайлбар 9	Нотлох баримтаар дэмжигдсэн тул саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар 10	Саналыг хүлээн авч өөрчлөлт оруулсан.